



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**



# **БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАГЧ:  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б.БААСАНДОРЖ**

**2020 ОН**

## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

|                                                                                                           |           |
|-----------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>НЭГ.ЕРӨНХИЙ ТОЙМ</b> .....                                                                             | <b>3</b>  |
| 1.1. Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай,<br>боловсронгуй болгох ажлын хүрээнд: ..... | 3         |
| <b>ХОЁР. БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....                                                               | <b>4</b>  |
| 2.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд : .....                                                         | 4         |
| 2.1.1. Цахим иргэний үнэмлэхийн бүртгэлийн чиглэлээр: .....                                               | 5         |
| 2.1.2. Үндэсний энгийн гадаад паспорт болон шилжин суурьших<br>хөдөлгөөний бүртгэлээр .....               | 6         |
| 2.1.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ажлын хүрээнд .....                                              | 7         |
| 2.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд: .....                                              | 10        |
| 2.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд: .....                                                | 13        |
| <b>ГУРАВ. УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ<br/>ХҮРЭЭНД</b> .....                         | <b>15</b> |
| <b>ДӨРӨВ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....                                           | <b>21</b> |
| 4.1. Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр: .....                                                          | 21        |
| 4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр: .....                                        | 22        |
| 4.3. Хуулийн этгээдийн архивын чиглэлээр: .....                                                           | 23        |
| <b>ТАВ. ХЭЛТСИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....                                                            | <b>23</b> |
| 5.1. Мэдээллийн технологи, програм хангамжийн ажлын хүрээнд: .....                                        | 23        |
| 5.2. Хүний нөөцийн ажлын хүрээнд: .....                                                                   | 26        |
| 5.3. Санхүү, аж ахуй, хангамж үйлчилгээний ажлын хүрээнд: .....                                           | 27        |
| 5.4. Үйл ажиллагааг тайлагнах ажлын хүрээнд: .....                                                        | 28        |
| 5.5. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд: .....                                 | 33        |
| 5.6. Сургалт, сурталчилгаа, ил тод нээлттэй байдал .....                                                  | 34        |
| 5.7. Олон нийтийн ажлын хүрээнд .....                                                                     | 47        |
| 5.8. Аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа,<br>уулзалтын талаар .....         | 49        |
| <b>ЗУРГАА. САНАЛ</b> .....                                                                                | <b>54</b> |

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## НЭГ.ЕРӨНХИЙ ТОЙМ

Тус хэлтэс нь 2020 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, УБЕГ-ын болон Хэлтсийн 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат, дамжлагыг багасгах зорилт тавьж ажилласан болно.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### **1.1. Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай,**

#### **боловсронгуй болгох ажлын хүрээнд:**

Тус хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээг аймгийн нийт иргэд хөдөлмөрчдөд хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, үйлчилгээний хүртээмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр гарын авлага болон бусад материалаар хангаж, бүртгэлийн бүрдүүлбэр хангуулсны үндсэн дээр мэдүүлэг хүлээн авах ажиллагаанд улсын бүртгэгчдийг сургасан болно..

Өнөөдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэлийг 5 хоногийн дотор, эд хөрөнгө өмчлөх эрх, гэрээ хэлцлийг 3 хоногийн дотор, яаралтай үйлчилгээний хөлс төлсөн барьцааны гэрээг ажлын 4 цагийн дотор тус тус бүртгэж, улсын бүртгэлийн үйлчилгээний шуурхай байдлыг ханган ажиллаж байна.

Хэвлэгдэж ирсэн иргэний цахим үнэмлэх, гадаад паспортуудыг эздэд нь утсаар мэдэгдэж үйлчлүүлэгчидтэй эргэх холбоотой ажиллаж байна. 16 нас хүрээгүй хүүхдийн паспорт олгоходоо “Хилээр гарах тохиолдолд төрсний гэрчилгээг хамт авч явах тухай санамж” хавсаргаж өгч үйлчилж байна.


## ХОЁР. БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”-уудыг мөрдлөг болгон ажиллав. Иргэний улсын бүртгэлд 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2388 иргэн хамрагдсанаас:

Төрсний бүртгэлд 1216, хүүхэд үрчлүүлсний 85, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний 14, эцэг тогтоосны 17, гэрлэсний 300, гэрлэлт дуусгавар болсны 19, гэрлэлт сэргээсний 1, нас барсны 244, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 192 иргэн, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээ дахин олголт 119, нөхөн бүртгэлийн бүртгэлд 181 иргэн тус тус бүртгэгдсэн байна.

/хүснэгт 1/




Нөхөн бүртгэлийн журмаар хамрагдсан 181 бүртгэлийг задалж үзвэл төрсний 24, үрчлэлтийн 5, гэрлэлтийн 124, нас баралтын 3 иргэн, овог эцэг /эх/-ийн нэр , нэр өөрчилсний бүртгэлд 2, регистрийн дугаар өөрчлөлтөөр 23 иргэн тус тус бүртгэгдсэн байна.

Төрөлт, гэрлэлтийн гэрчилгээгээ гээгдүүлсэн болон гэмтээсэн шалтгаанаар дахин олголтоор төрсний 102, гэрлэлтийн 17 гэрчилгээг нийт 119 иргэнд олгосон.

Регистрийн дугаар, хүйс зөрүүтэй, шүүхийн шийдвэрээр нас тогтоолгосон, төрсөн, он, сар, өдөр давхцаж олгогдсон, огт бүртгэгдээгүй зэрэг нийт 23 иргэний регистрийн дугаарын бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүртгэв Тайлангийн хугацаанд гадаадын иргэний бүртгэлд нийт 10 иргэн хамрагдсанаас төрсний 9, гэрлэлтийн 1 тус тус бүртгэгдсэн байна.

/ хүснэгт 2 /



Сумдаас ирүүлсэн иргэний бүртгэлийн мэдээг хянах явцад нийт **25** зөрчилтэй бүртгэл илэрсэн бөгөөд зөрчилтэй гэх маягтуудыг сум руу буцаан хүргүүлж зөвтгүүлэн мэдээллийн санд тусгуулсан.

Хугацаа хэтэрсэн гэх 25 ИУБ маягтыг хяналтын улсын байцаагчид тухай бүр хянуулж ажилласан.

Онлайн бүртгэлийн системд шивж баталгаажуулсан 1895 маягтыг Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 22.2-т заасны дагуу үсгийн дарааллаар галиглан ажлын 7 өдрийн дотор дагалдах хуудсын хамт “А” талыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний баримтын архивт, “Б” талыг иргэний баримтын архивт жагсаалтын хамт тус тус хүргүүлж ажилласан.

### **2.1.1. Цахим иргэний үнэмлэхийн бүртгэлийн чиглэлээр:**

Тайлангийн хугацаанд иргэний цахим үнэмлэхний чиглэлээр дараах ажлыг хийлээ. Шинэчилсэн бүртгэлд шинээр хамрагдсан 1889 иргэнээс 1422 хүүхдийн хаягийг жагсаалтаар хүргүүлж мэдээллийн санд тусгуулан баталгаажуулсан.

Шинэчилсэн бүртгэлд мэдээллийг алдаатай бүртгэсэн 43 иргэнд хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан нийтдээ 353 хүний үсгийн алдааны засвар өөрчлөлт, ургийн овог оруулах, нэрийн баталгаажилт, хаягийн өөрчлөлтийг зохих журмын дагуу оруулж ажилласны дүнд нийтдээ 2484 иргэний цахим үнэмлэхийг баталгаажуулсан.

УБЕГ-аас 2020 оны хагас жилийн байдлаар хэвлэгдэж ирсэн 2484 иргэний цахим үнэмлэхийг хүлээн авч сумдаар нь ялгалт хийн, нэрсийн жагсаалтад авч нэгжийн бүртгэгчдэд хүлээлгэн өгсөн байна.

Сумдын бүртгэгчдээс ирсэн иргэний үнэмлэхний 288 дахин олголтын материалыг зохих журмын дагуу хянуулсны дараа нэмэлтээр оруулан баталгаажуулалт хийсэн болно. Үүнд: иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн 244,

хүчинтэй байдлаа алдсан 18, төрсөн он тогтоолгосон 8, хаягийн хөдөлгөөн 12, овог нэр сольсон 6 байна.

Иргэний үнэмлэхийн 25 насны сунгалтад 792, 45 насны сунгалтад 572 иргэн хамрагдаж, нийтдээ 1364 сунгалтын бүртгэлд баталгаажилт хийгдэж цахим үнэмлэх хэвлэгдсэн байна.

Иргэний цахим үнэмлэхний олголтын бүртгэл хийгдсэн 2484 ИУБ-21 маягтыг мэдээллийн санд шивж оруулж, цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан “А” талын УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газар болон архивын газарт, “Б” талыг хэлтсийн иргэний бичиг баримтын архивт тухай бүр хүлээлгэн өгсөн болно. /хүснэгт 4/



Ургийн овог болон нэрийн санд нэр нь баталгаажуулж, ургийн овог нэрийн санд тусгагдаагүй, эцгийн нэр болон нэр нь нэрийн санд үсгийн алдаатай, мэдээллийн санд хаяг тусгагдаагүй 310 иргэний жагсаалтыг 7 хоног бүр УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газарт хүргүүлэн, зөрчил арилсаны дараа баталгаажуулж байх ба иргэдэд олгосон цахим иргэний үнэмлэхний ИУБ-21 маягтыг шивэлт 100 хувьтай байна.


### **2.1.2. Үндэсний энгийн гадаад паспорт болон шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлээр**

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 126 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах тухай”, УБЕГазрын даргын 2018 оны А/394 тушаалаар батлагдсан журам, мөн ХЗДХСайдын 2018 оны 11-р сарын 01-ний өдөр баталсан дугаар А/207 “Иргэний улсын бүртгэл хөтлөх” журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Үндэсний энгийн гадаад паспорт олголтын чиглэлээр 1628 иргэний захиалга хүлээн авч 7 хоног бүр УБЕГ-т хүргүүлсэн байх ба 1598 иргэнд гадаад паспорт шинээр олгосон байна. Гадаад паспортын тэмдэгтийн хураамжинд 8,140,000 /найман сая нэг зуун дөчин мянга/ төгрөг төвлөрүүлсэн байна.

Үндэсний энгийн гадаад паспортыг биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл болох хурууны хээг уншуулан мэдээллийн санд улсын бүртгэгч бүртгэх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэн захиалгыг аван үйлчилж байна.

Хүчинтэй хугацаа буюу хуудас дууссан, хаяж үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан зэрэг шалтгаанаар 837 иргэний үндэсний энгийн гадаад паспортыг хүчингүйд тооцуулсан байна. 2020 оны 1 дүгээр сараас эхлэн дэлхий дахинд дэгдээд буй Корона вирусын цар тахлын улмаас гадаад улсад зорчих иргэдийн хөдөлгөөн буурсанаар тус аймагт паспортын захиалга буурсан байна. /хүснэгт 5/



Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 332 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын нутаг дэвсгэрт иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журмыг мөрдлөг болгон ажилласан байна. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр нийтдээ 1376 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдсанаас: аймаг хотоос бүрмөсөн шилжин ирсэн 67, аймаг хот доторх шилжилт хөдөлгөөнд 1309 иргэн тус тус хамрагдсан байна. 2019 оны 12 дугаар сард батлагдсан Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд заасны дагуу 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр УБЕГ-ын даргын тушаалаар түр зогсоосон.

### **2.1.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ажлын хүрээнд**

УБЕГ-ын даргын баталсан Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг тус хэлтсээс авч хэрэгжүүллээ. Үүнд:

1. Монгол улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1-д заасны дагуу иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг түр зогсоосон тухай УБЕГ-ын даргын тушаалын

хэрэгжилтийг хангаж шилжих хөдөлгөөний бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зогсоосон.

2. Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг хүлээн авахдаа эх хувийг нягтлан шалгаж авч, Иргэний улсын бүртгэлийн газарт хэсэг оноох, сонгуулийн төвийг зарласан санал авах байрны хэсгийн төвийг мэдээллийн санд шивж оруулах улсын бүртгэгч нарт эрх нээлгэх бичгийн хамт 2020 оны 2 дугаар сарын 20-ний өдрийн албан бичгээр хүргүүлж ажилласнаар улсын ахлах бүртгэгч, төвийн 3 бүртгэгч, Өлгий, Сагсай, Бугат сумдын улсын бүртгэгч нарт эрх нээлгүүлж хүчийг зөв хувиарлан санал авах байрны мэдээллийг 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс мэдээллийн санд тусгуулан, 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хянаж баталгаажуулалтыг хийж гүйцэтгэсэн болно. Тус аймаг нийт 13 сум 97 багтай ба УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу 96 хэсэг байгуулсан байгаа. Бугат сумын 5-р баг 100 гаруй сонгогчтой учраас сумын төв буюу 3 дугаар багтай нэгтгэж хэсэг байгуулсан болно.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газраас сонгуулийн хэсгийг дугаарлаж, сонгуулийн хэсэгт байнга оршин суух хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэнд хэсэг оноосны дараа хэсэг оноогдсон мэдээллийг улсын бүртгэгч нараар шалгуулсан болно. Шалгуулах явцад хэсэг оноогдоогүй 4 сонгогч буюу иргэнд хэсэг оноов.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 8/3377 тоотой ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу тус хэлтэст 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд бүртгэгдсэн нийт 1597 шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2 удаа нягтлан шалгасан байна.

4. УБЕГ-ын даргын 2020 оны А/372 дугаар тушаалаар батлагдсан “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам”-ыг хүлээн авч нийт улсын бүртгэгч нарт танилцуулан хүргүүлсэн ажиллав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам”-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах ажлын хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.



1. Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, санал авах байрны хэсгийн төвийг дахин нягталж тулгалт хийсэн болно.

2. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол дахь сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүрэн бүртгэгдсэн эсэхийг [election.gasr.mn](http://election.gasr.mn)-ээс тогтмол шалгаж хэсэг оноогдоогүй орхигдсон сонгогчдод тухай бүр хэсэг оноолт хийсэн болно. Үүнд 2017 оноос хойш шилжин явсан боловч тодорхой хаяггүй болсон 24 иргэний нэрсийг тодруулан тухайн иргэдтэй холбогдон 4 иргэнээс хүсэлт авч өөрийн оршин сууж байгаа хаягийн нотлох баримтуудыг авч ИУБГ-т хүргүүлсэн болно. Бусад тодорхой хаяггүй иргэд өөр аймаг хот руу шилжин явсан шалтгаантай байна.

3. Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр ижил нэртэй 110 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас нэг бүрчлэн шалгаж сонгуулийн аль хэсэгт бүртгэгдсэнийг нягталж тэмдэглэл хөтөлсөн болно. Эдгээр иргэдээс давхар регистрийн дугаартай 48 иргэний мэдээлэл хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүй болсон.

4. Тус аймагт 2017 оноос хойш ХААТР-25 маягтаар Монгол Улсын иргэний регистрийн дугаарыг өөрчилсөн, хүйс зөрүүлж олгосон, давхар регистрийн дугаартай зэрэг шалтгаантай холбоотой гарсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр иргэний улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан нийт 143 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь иргэний мэдээлэлтэй тулгаж зөрчил арилсан эсэх, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл санд туссан эсэхийг нягтлан шалгахад ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

5. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр бүртгүүлсэн болон 25, 45 насанд сольж, хаяж, үрэгдүүлсэн шалтгаанаар дахин олгох бүртгэлд бүртгүүлж байгаа иргэдийн бүртгэлийг баталгаажуулахдаа иргэний оршин суух хаягийн мэдээлэл сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт бүртгэгдсэн эсэхийг байнга нягтлан шалган, тулгалт хийж ажилласан болно.

6. Тус хэлтэст болон сумдын улсын бүртгэгч нарт үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд байгууллагын цахим хуудсанд байршуулсан сонгогчийн нэрийн жагсаалт дахь өөрт холбогдох мэдээлэлтэй танилцах боломжийг хангаж үйлчилгээний зааланд интернет холбогдсон компьютер байршуулсан. Мөн үйлчлүүлж байгаа

иргэн бүрт сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй эсэхийг шалгах талаар тухай бүр мэдээлэл өгч ажиллаж байгаа болно.

УБЕГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Итгэмжлэгдсэн ажилтны орон тооны дээд хязгаарыг батлах тухай” А/521 дүгээр тушаалын дагуу тус аймгийн сонгуулийн санал авах байрны дэргэд ажиллах 108 итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргаж аймгийн Тагнуулын газраар шалгуулсны үндсэн дээр Хэлтсийн даргын тушаалаар томилон ажиллуулж байна. Итгэмжлэгдсэн ажилтнаар Нууцын баталгаа гаргуулан, Ажил гүйцэтгэх гэрээг байгуулав. Итгэмжлэгдсэн ажилтнуудын ихэнх нь өмнөх сонгуульд ажиллаж байсан туршлагатай төрийн албан хаагч нар бөгөөд шинээр томилсон ажилтнуудыг УБЕГ-аас ирсэн чиглэлийн дагуу багш нараар бүрдүүлсэн болно./ИА-нуудын 40 нь багш, 22 улсын бүртгэгч, бусад нь сумын ЗДТГ-ын ажилтнууд болно./


Итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн сургалтыг 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдөр цахим болон танхимын хэлбэрээр, 2020 оны 6 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд ирц бүртгэлийн программын сургалтыг УБЕГ-ын Сургалтын багтай хамтран танхимын хэлбэрээр тус тус зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 2 дугаар тойрог Баян-Өлгий аймгийн 13 сумын 96 хэсгийн нэрийн жагсаалтыг хуульд заасны дагуу 2 удаа хэвлэж сонгуулийн хэсгийн хороодод хүргүүлэх ажлыг зохион байгуулав.


## **2.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулж тайлант хугацаанд нийтдээ 3663 мэдүүлэг хүлээн авч хянан шийдвэрлэсэн. Үүнээс, газар өмчлөх эрхийн бүртгэл 282, газар эзэмших эрхийн бүртгэл 738, шинээр баригдсан орон сууцны өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 37, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 299 бүртгэл тус тус бүртгэж эрхийг нь баталгаажуулсан ба эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт, залруулга оруулах бүртгэл 268, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэлд өөрчлөлт оруулах 6 эрхийн бүртгэл тус тус бүртгэж баталгаажуулсан болно.


### **Мэдүүлэг, анхны бүртгэл, гэрээ хэлцэл**



Тайлант хугацаанд нийт 2693 гэрээ хэлцэл бүртгэж баталгаажуулсан бөгөөд худалдах худалдан авах гэрээ 295, албадан дуудлага худалдаа 2, өмчлөгчийн үүсгэн байгуулсан хуулийн этгээдээс иргэнд, иргэнээс хуулийн этгээдэд өмчлөх эрх шилжих гэрээ 3, бэлэглэх гэрээ 100, гэрээслэл болон өв залгамжлал 68, барьцаалбартай барьцааны гэрээ 435, барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 41, барьцаалбаргүй барьцааны гэрээ 589, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 225, барьцааны гэрээ дуусгавар болгох 896, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 39 гэрээг тус тус бүртгэж баталгаажуулсан байна.




Эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 47 лавлагаа, хуулбар гаргаж өгсөн байна. Хууль хяналтын байгууллагаас гаргасан албан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх лавлагаа мэдээлэл 65-г албан тоотоор хүргүүлэн ажиллав.



2020 оны эхний 6 сарын байдлаар нийт 3663 бүртгэл хийсэн ба үүнээс 630 нь анхны бүртгэл, 738 нь газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл, 2693 нь гэрээний бүртгэл, үлдсэн 340 нь бусад төрлийн бүртгэл байна.

2020 оны эхний хагас жилд үйлчилгээний хураамжаар 83,956,496.92 төгрөг, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдан борлуулсаны 2%-ын татварын орлогоор 41.304.350 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 1.366.620 төгрөг, нийт 126.627.466 төгрөгийн орлогыг орон нутгийн болон улсын төсөвт оруулсан байна.

**Үйлчилгээний хураамж, Улсын тэмдэгтийн хураамж, 2%-ийн татвар.**



Иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцуулах газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 7, газар өмчлөх эрхийн 7, эрхийн улсын бүртгэлийг хаах газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 23, буюу нийт 37 мэдүүлэг хүлээн авч хууль журмын дагуу ЭХЭУБГ-т хүргүүлж, УБЕГ-ын даргаас гарсан тушаалыг үндэслэн

үрэгдүүлсэн гэрчилгээг иргэн, хуулийн этгээдэд дахин олгож, хаах хувийн хэргүүдийг архивт хүлээлгэн өгсөн болно.

### **2.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:**

2020 оны эхний хагас жил /5 сарын 25-ны мэдээгээр/ нийт 96 хуулийн этгээдийг цахим санд бүртгэж гэрчилгээ олгосон. Нийт шинээр нээгдсэн 78, үүсгэн байгуулах баримт бичигт нь нэмэлт өөрчлөлт орсон 140, тамга тэмдэгийн хяналтын дугаар олголтын 83, дахин гэрчилгээ олгосон 14, лавлагаа , хуулбар 128 нийт 443 бүртгэл хийгдсэн.

Тайлант хугацаанд нийт 128 лавлагаа, хуулбарыг иргэн,хууль, хяналтын байгууллага, хуулийн этгээд, бусад байгууллагын хүсэлтээр олгосон. Хуулийн этгээдийн гэрчилгээг ашиглах боломжгүй болгосон, гэрчилгээ гэмтээсэн, үрэгдүүлсэн, хэлбэрээ өөрчилсөн нийт 14 хуулийн этгээдэд дахин гэрчилгээ олгов.

Мөн 4 салбар, төлөөлөгчийн газрын бүртгэлийг хийж, холбогдох бүрдүүлбэрийг ХЭУБГазарт хүргүүлэн ажиллав.

2020 оны шинээр болон нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл хийлгэсэн нийт 232 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийг хуулийн хүрээнд хийж, цахимжуулсан болно. Тайлант хугацаанд 97 хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг ERS программд шүүж, нэр баталгаажуулах журмыг дагуу олгосон.

Сумдын бүртгэгч нарт 16 удаа хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой асуултанд утсаар болон биечлэн зөвлөгөө өгч ажиллав. Мөн сумдын бүртгэгч нараас ирсэн бүрдүүлбэрийг хянан шалгаж, дутуу материалыг нь буцаан, тухай бүр чиглэл өгч ажиллав. Шинээр бүртгэгдсэн хуулийн этгээдүүдийг үдэж хавтаст хийн, УБЕГ-ын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу архивчид хүлээлгэн өгч, нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн этгээдүүдийн материалыг журмын дагуу дугаарлаж УБЕГ-ын 2019 оны А/1050 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу нэмэгдсэн хуудсуудын тоогоор архивт шилжүүлж ажиллав.

Тайлант хугацаанд нийт 365 хувийн хэргийг татан авч архивт буцаан оруулсан. Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээг сар, улирал бүрээр цаг хугацаанд нь гаргаж өгөв. Тамга, тэмдэг олголтын мэдээг сар болгон гаргаж хүргүүлэн ажиллав. Удирдлагаас өгсөн бусад нэмэлт мэдээ тайлангуудыг хугацаанд нь хүргүүлж ажиллав. ХЭУБТХуулийн дагуу бүрдүүлэх материалын жагсаалтыг байгууллагын самбарт болон ажлын өрөөндөө байнга байрлуулж

ажиллаж байна. Зөвлөгөө авахаар ирсэн давхардсан тоогоор 1436 гаруй иргэнд нэг бүрчлэн хуулийн хүрээнд заавар зөвлөгөө өгч, нэрсийн жагсаалтыг он, сар, өдрөөр хөтлөн ажиллав.


2020 оны 4 сард хэлтсийн даргын үүрэг болгосноор “COVID-19-ийн үед хувийн хамгаалах арга хэмжээ авах УБЕГ-ын даргын 1-4/1190 тоот, УБЕГ-ын А/419 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 4,5 дугаар зүйл, мөн тушаалын 2 дугаар хавсралтын 4,5-д зааснаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” боловсруулан батлуулж, 2020 оны 04 сарын 08-ны өдөр үйлчилгээний зааланд болон ажилтнууд өөр өөсдийн ажлын байрандаа их цэвэрлэгээ хийж, 4 сарын 13-ны өдөр албан хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс биеийн халууныг хэмжүүлэх, ажлын байранд хийж болох дасгал хөдөлгөөн заалгахаар “Жансая” өрхийн эмнэлэгийн 2 эмчийг ирүүлж холбогдох ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн болно.

УБЕГ-аас зохион байгуулсан “Тамга, тэмдэг ашиглах” чиглэлийн, итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулан явуулсан 2 онлайн сургалтанд, ХЭУБГ-аас “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэл хөтлөх, анхаарах асуудал”, “Хуулийн этгээдтэй холбоотой хууль, журмын хэрэгжилт, анхаарах асуудал” зэрэг онлайн сургалтуудад тус тус биечлэн оролцож, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны 01 сарын 01-нээс өмнө үүсгэн байгуулж үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газраас бусад нийт хуулийн этгээдүүдийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал нарт 2020 оны 12 сарын 31-нээс өмнө “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх” талаар орон нутгийн 9-ийн радиогаар өөрийн биеэр ярилцлага өгч, “эцсийн өмчлөгч”-ийн анхан шатны ойлголт өгч ажиллав. Мөн 2020 оны 05 сараас 07 сар хүртэл “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх” талаар орон нутгийн “Дербес” телевизээр олон нийтэд зар, мэдээлэл тавьж, эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаж байна.

Мөн 2020 оны эхний улиралд хэлтсийн вэб сайтанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нийт бүрдүүлбэрийг шинэчилж, мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн өргөдлийн маягт болон бусад загвар, маягтуудыг шинэчилэх чиглэлээр хэлтсийн мэдээлэл, технологийн ажилтантай хамтарч мэдээ, мэдээллийг шинэчилэн ажиллалаа.

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой иргэн, хуулийн этгээдтэй холбоотой 49 албан тоот хүлээн авч, хариу хүргүүлсэн болно.



## **ГУРАВ. УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ХҮРЭЭНД**

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18.7.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/289 дугаар тушаалаар баталсан Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасныг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөхдөө холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, улсын бүртгэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэн, улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг илрүүлэн түүнийг таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулан Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, иргэн хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж, засвар өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийн хангуулж ажиллаж байна.

### **НЭГ: ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ:**

Иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, санал, гомдлоор 405 улсын бүртгэлд хяналт, шалгалт хийж хуулийн дагуу 91 бүртгэлд дүгнэлт гаргаж, нийт 292 иргэний иргэний бүртгэлийн зөрчлийг арилгасан, 314 бүртгэлд тухай бүр шийдвэр гаргаж, 404 иргэний хууль тогтоомж зөрчсөн зөрчил гаргасныг илрүүлэн

хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж нийт 8,910,000 төгрөгийн торгууль ногдуулсан болно.

Иргэний цахим үнэмлэх хүчингүй болгох тухай 288, 35 гадаад паспорт, 395 улсын бүртгэлийн гэрчилгээг тус тус хүчингүй болгосон.

Батлагдсан төлөвлөгөө, удирдамжын дагуу иргэний бүртгэлийн тасгийн 3 Улсын бүртгэгч, 13 сумын улсын бүртгэгч нарын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт, гүйцэтгэлийн 14, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 19 удаа хянаж шалгасан ба 15 албан шаардлага гаргаж хүргүүлсэн. Иргэний улсын бүртгэлийн нийт 13784 улсын бүртгэлд хяналт тавьсан, 6480 бүртгэлийг шалгаж 130 зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулав.

Иргэдээс улсын бүртгэлийн зөрчил арилгуулах болон хяналтын байцаагчийн дүгнэлт гаруулахаар 314 өргөдөл хүлээн авч 91 дүгнэлт гаргаж, хууль журмын дагуу хянаж шийдвэр гаргаж, хариу мэдэгдсэн болно. Дүгнэлтийн хувьд: Бүртгэл хүчингүй болгох тухай 16, бүртгэл хийх тухай 5, зөрчил арилгах тухай 35, регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай 18, Регистрийн дугаар хүчингүй болгох тухай 1 / давхар регистрийн дугаартай 50 иргэний/, регистрийн дугаар сэргээх тухай 1, нас барсан бүртгэлийг бүртгэх тухай 15, үрчлэлтийн бүртгэл нөхөн бүртгэх тухай 1, гэрлэлтийн бүртгэл нөхөн бүртгэх тухай 3, Хориг хүчингүй болгох, төлөвт нэмэлт өөрчтүхэй 1, гадаад паспортын хориг цуцлах тухай 1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим санд оруулах тухай 5, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг цахим бүртгэлд оруулах тухай 4, Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүйд тооцох, дахин олгох тухай 1, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 33 дүгнэлт гаргаж 185 улсын бүртгэлийн бүртгэлийн зөрчлийг арилгасан болно.

Өргөдөл гаргасан 287 иргэний өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгаж хариу өгсөн ба бүртгэлийн хууль тогтоомжийн талаар 14 улсын бүртгэгчид зөвлөгөө, зааварчилгаа өгч бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.

Хяналтын улсын байцаагчийн хувьд шүүхийн шийдвэрийг үндэслэн бүртгэл хүчингүй болгох, бүртгэл хийлгэх тухай 8 иргэний өргөдлийг шүүхийн шийдвэрийн хамт хүлээн авч хянаад холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

Баян-Өлгий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 26-ы өдрийн 29 дүгээр тогтоол, 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 80 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хаягийн бүртгэлд бүртгэх тухай 1382 иргэнд холбогдох 1 дүгнэлт гаргасан байна.



Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны явцад хуримтлагдсан 10 боть нотлох баримтыг хууль журмын дагуу 250 хуудас бүхий нэгж үүсгээд архивт хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон.

### **ХОЁР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВЬСАН ТУХАЙ:**

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журамд заасны дагуу улсын бүртгэлийн алдаа зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус хэлтсийн улсын бүртгэгч нарын хөтөлсөн нийт 16533 бүртгэлд хяналт тавьсан байна. Үүнд: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 13784, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2182, Хуулийн этгээдийн чиглэлээр 126, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 441 бүртгэлд түүвэрчилсэн болон байнгын хяналт тавьсан байна.

**ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:** Иргэний улсын бүртгэлийн төрсний бүртгэл 530, үрчилсний бүртгэл 55, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 10, эцэг тогтоосны бүртгэл 17, гэрлэсний бүртгэл 208, гэрлэлт цуцалсны бүртгэл 15, нас барсны бүртгэл 211, иргэний шилжих хөдөлгөөний 192, Иргэний үнэмлэх дахин олгох 215, иргэний бичиг баримт дахин олгох 314 бүртгэлд, олгосон лавлагааны 302, иргэний үнэмлэх олгох 1200, иргэний шилжих хөдөлгөөний бүртгэл зэрэг бүртгэлд тус тус хяналт тавьсан болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн №8/409 дугаар бүхий чиглэл, 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 2/4861 дугаар бүхий чиглэлийн дагуу Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 13 сум, 1 тосгоны улсын бүртгэгч нарын 2019 оны 12 сарын 10-аас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл бүртгэсэн шилжих хөдөлгөөний нийт 1597 бүртгэгдсэн бүртгэлд хоёр удаа эх нотлох баримт, цахим мэдээллийн санд хяналт шалгалт хийхэд Өлгий сумаас 7, Толбо сум 2, Баяннуур сум 4, Цэнгэл сум 1, Буянт сум 1, Алтанцөгц сум 1, Бугат сум 2, Булган сум 3, Улаанхус сум 5, Алтай сум 5, Цагааннуур тосгоны 3 зөрчилтэй бүртгэл тус тус илэрсэн болно. Зөрчлийг арилгах зорилгоор холбогдох албан хаагч нарт зөрчил арилгах тухай №06 дугаартай улсын байцаагчийн шаардлагыг хүргүүлж биелэлтийг хангуулсан болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагч Д.Чинтулгын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн №10

дугаар шаардлагын биелэлтийг хангах, зөрчлийг арилгах зорилгоор хууль тогтоомж зөрчиж бүртгэсэн 26 иргэний бүртгэлийг хүчингүй болгох тухай дүгнэлт гаргаж хянан шийдвэрлэсэн болно.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчдын бүртгэлийг нягтлан шалгах хүрээнд 96 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай 1240 иргэний эх нотлох баримтыг хянаж шалгав. Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай 1236 лавлагааг программд шивэх нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг 108 итгэмжлэгдсэн ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан ба хууль журам зөрчиж гаргасан 4 лавлагааг хүчингүй болгох тухай дүгнэлт тус тус гаргаж ажиллав.

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:** Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журамд заасны дагуу Хуулийн этгээдийн шинээр бүртгэгдсэн 15, Төрийн байгууллага, албан газар, төсөвт үйлдвэрийн газар 2, Нөхөрлөл 1, Хоршоо 2, Төрийн бус байгууллага 16, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 24, нэрийн баталгаажуулалт 45 бүртгэгдсэн бөгөөд нийт 126 бүртгэлд давхардсан тоогоор хяналт тавьсан байна.

#### **ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр нийт 2182 бүртгэлд хяналт тавьсан байна. Үүнд:

Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах, эрхийн 35, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл 120, газар өмчлөх эрхийн бүртгэл 65, нэмэлт өөрчлөлтийн 138 бүртгэлд, 56 лавлагаа, худалдах худалдан авах гэрээ 45, бэлэглэх гэрээ 35, гэрээслэл болон өв залгамжлал 5, барьцааны гэрээ 320, барьцаалбар 42, барьцааны гэрээ дуусгавар болгох 40, хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ 35 буюу нийт 936 бүртгэлд түүвэрчилсэн хяналт тавьсан болно.

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:** 2020 оны тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн архивын чиглэлээр нийт 871 иргэн, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбогдох эх нотлох баримт бүртгэлд хяналт тавьсан байна. Үүнд иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, санал, гомдол, мэдээллийн мөрөөр 355 улсын бүртгэлийн эх нотлох баримтын бүртгэлд, хяналт, шалгалт хийж хууль журмын дагуу 178 бүртгэлд дүгнэлт гаргаж, 112 бүртгэлд

тухай бүр шийдвэр гаргаж хариу өгч, 172 иргэний хүсэлтийг хүлээн авч архивт хадгалагдаж буй эх нотлох баримт, бүртгэлийг газар дээр нь хянаж улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн чиглэл өгч ажилласан байна.

## **ГУРАВ: ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД:**

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу бүртгэлийн үйл ажиллагаанд байнга хяналт тавьж ажилласан ба иргэний, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гэнэтийн шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, арга хэмжээ авч, гарч буй зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид таслан зогсоох зорилгоор зөрчил гаргасан улсын бүртгэгч, сумдын улсын бүртгэгч нарт зөрчигдсэн хууль тогтоомж, журмыг тайлбарлан заавар зөвлөгөөг тухай бүр нь өгч, 4 удаа хууль эрх зүйн сургалт зохион байгуулан, бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Хяналтын байцаагчийн үйл ажиллагааны 2020 оны эхний улирлын төлөвлөгөө, удирдамжын дагуу Иргэний бүртгэлийн тасгийн Улсын ахлах бүртгэгч 1, улсын бүртгэгч 4, Эд хөрөнгийн тасгийн Улсын ахлах бүртгэгч 1, 4 улсын бүртгэгч 4, болон 13 сумын улсын бүртгэгч нарын, хэлтсийн иргэний баримтын, эд хөрөнгийн бүртгэлийн, хуулийн этгээдийн бүртгэлийн 2 архивын архивч бүртгэлийн үйл ажиллагааг Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад эрхийн актад нийцүүлэн хөдөлж байгаа эсэхэд төлөвлөгөөт шалгалт 20, гүйцэтгэлийн 14, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 99 удаа хийсэн ба илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоож, бүртгэлийн хууль тогтоомж хийсэн хууль бус 20 бүртгэлийг хүчингүй болгон 35 бүртгэлийн зөрчлийг арилгах, Цахим мэдээллийн санд оруулах залруулга хийх тухай 23 дүгнэлт гаргасан.

Бүртгэл хүчингүй болгох, зөрчил арилгах тухай дүгнэлтэд албан үүрэгтээ хайнга хандаж, улсын бүртгэлийн холбогдох хууль тогтоомжийг зөрчиж бүртгэл хөтөлсөн, зөрчил арилгах таслан зогсоох арга хэмжээ аваагүй Эд хөрөнгийн тасгийн 1 улсын бүртгэгчид Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилгын арга хэмжээ авах тухай саналыг Захиргаа, эрх зүйн хэлтэст хүргүүлэв. Иргэний биеийн давхацахгүй өгөгдлийн бүртгэлийн зөрчил гаргасан, бүртгэл хийхээс үндэслэлгүй татгалзсан 11 улсын бүртгэгчид анхааруулга өгч зөрчлийг нэн даруй арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

## **БУСАД АЖИЛ:**

Улсын бүртгэлийн багц хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй асуудлын талаар, Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй асуудлын талаарх саналыг холбогдох газарт 3 удаа хүргүүлж, цаг үеийн болон хуулийн хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэгт оролцож 2 удаа итгэл тавьсан, 1 удаа прокурорын байгууллагын зохион байгуулсан ажлын байран дахь стресс болон сэтгэл зүйн сургалтад хамрагдав..

Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой журмын төсөлд 2 удаа, зөрчлийн тухай хуульд 1 удаа санал өгсөн болно..

Иргэн хуулийн этгээдэд холбогдох улсын бүртгэлийн талаар хуульд заасан журмын дагуу зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Үүнд: Сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т заасан Иргэний Засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01-нээс санал авах өдрийн дараах өдөр хүртэл түр зогсоохтой холбоотой болон иргэний шилжих хөдөлгөөний бүртгэлд гарч буй зөрчлийн талаар орон нутгийн телевизээр 6 удаа Саян тв, Дервес тв мэдээлэл хийсэн болно.

**2020 оны эхний хагас жилд** дунджаар 1338 орчим иргэн, хуулийн этгээдийн эрх бүхий этгээдэд холбогдох улсын бүртгэлийн талаар ил тод, нээлттэй зөвлөгөө өгч үйлчилж ажиллав.

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу бүртгэлийн үйл ажиллагаанд байнга хяналт тавьж ажилласан ба иргэний, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гэнэтийн шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, арга хэмжээ авч, гарч буй зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид таслан зогсоох зорилгоор зөрчил гаргасан улсын бүртгэгч, сумдын улсын бүртгэгч нарт зөрчигдсэн хууль тогтоомж, журмыг тайлбарлан заавар зөвлөгөөг тухай бүр нь өгч, 3 удаа хууль эрх зүйн сургалт зохион байгуулсан.

Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны статистик мэдээг сар бүрийн Хяналт шалгалтын газарт, хялбаршуулан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн шийтгэл оногдуулсан тухай мэдээг Хяналт шалгалтын газар, Прокурорын газарт, Хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг Тамгын газарт, Үнэт цаасны мэдээг санхүүд гаргаж, тус тус хуулийн хугацаанд бүрэн хүргүүлж ажиллаж байна.

Хяналт шалгалтын газрын чиглэлийн дагуу Баян-Өлгий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 13 сум, 1 тосгоны 96 хэсгийн 64418 сонгогчийн нэрийн жагсаалт үйл ажиллагаанд эрх үүргийн дагуу хяналт тавьсан болно.

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч би сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах, сонгуулийн өдөр програмд хэрхэн ажиллах, тайлан гаргах зэрэг нийт 96 хэсгийн 108 иртгэмжлэгдсэн ажилтан нарын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан болно. Үүнд:

1. Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай 1238 лавлагааг программд шивэх үйл ажиллагаанд хяналт тавьсан, тухай бүр арга зүйн зөвлөгөө үзүүлж сургасан, дэмжлэг үзүүлэн дахин нягталж нэг бүрчлэн өөрчлөлтийн тайлантай тулгаж шалгасан болно.

## **ДӨРӨВ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **4.1. Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр:**

Тус хэлтсийн иргэний баримт бичгийн архив нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар улсын бүртгэгч нараас 2500 маягтыг хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглаж байршуулсан. Өнөөдрийн байдлаар иргэний баримтын архивт нийт 224854 хувийн хэрэг хадгалагдаж байна. Тайлант хугацаанд нийт 5534 лавлагаа олгосноос:


| Лавлагааны төрөл                     | 2019      | 2020 он      |              |            |            |            |            | Нийт         |
|--------------------------------------|-----------|--------------|--------------|------------|------------|------------|------------|--------------|
|                                      | 12 сар    | 1 сар        | 2 сар        | 3 сар      | 4 сар      | 5 сар      | 6 сар      |              |
| 1 дүгээр маягтын                     |           | 4            | 9            | 2          | 3          | 2          |            | 20           |
| Гэрлэлт бүртгэлгүй тухай             | 5         | 145          | 72           | 60         | 70         | 53         | 21         | 426          |
| Гэрлэлт цуцлалтын                    |           |              | 1            | 1          | 2          | 1          | 1          | 6            |
| Гэрлэлтийн бүртгэлийн                | 3         | 99           | 67           | 61         | 73         | 78         | 22         | 403          |
| Нас барсны                           | 20        | 107          | 77           | 53         | 66         | 71         | 19         | 413          |
| Оршин суугаа хаягийн                 |           | 23           | 10           | 6          | 18         | 11         |            | 68           |
| Регистрийн дугаар сольсон тухай      | 3         | 4            | 7            | 11         | 5          | 9          | 5          | 44           |
| Төрсний                              | 18        | 842          | 511          | 515        | 340        | 345        | 211        | 2,782        |
| Төрөл садангийн тухай                |           | 13           |              | 5          | 2          | 5          | 5          | 30           |
| Төрөлт бүртгэлгүй тухай              | 3         | 14           | 5            | 15         | 10         | 11         | 2          | 60           |
| Хүүхэд үрчлэлтийн                    | 2         | 51           | 45           | 28         | 28         | 39         | 14         | 207          |
| Цахим үнэмлэх                        | 17        | 189          | 196          | 134        | 152        | 161        | 84         | 933          |
| Эцэг /эх/-ийн нэр, нэр сольсон тухай | 1         | 38           | 29           | 34         | 16         | 13         | 4          | 135          |
| Эцэг тогтоосон тухай                 |           | 3            | 2            |            |            | 2          |            | 7            |
| <b>Нийт</b>                          | <b>72</b> | <b>1,532</b> | <b>1,031</b> | <b>925</b> | <b>785</b> | <b>801</b> | <b>388</b> | <b>5,534</b> |

Хууль хяналтын байгууллагаас ирсэн нийт 238 ширхэг албан тоотыг хүлээн авч холбогдох нийт 834 ширхэг эх нотлох баримт болон маягтуудыг хуулбарлан хүргүүлэв. Регистрийн дугаар буруу, хүйс зөрүүтэй, ИУБ маягт нөхүүлэх МУ-санд ороогүй, нас тогтоолгох, төрөлт тогтоох, нас баралт тогтоох, шүүхийн журмаар

гэрлэлт цуцлалт г.м зөрчлийг арилгахын тулд нийт 179 иргэний хувийн хэргийг Архивын фондоос захиалгын хуудсаар бүртгэл хөтөлж Улсын бүртгэгч, Хяналтын улсын байцаагч нарт өдөртөө гаргаж буцаж архивт хүлээн авч байрлуулан ажиллав.

Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нарын 2019 онд хийж гүйцэтгэсэн бүртгэлийн эх нотлох баримтын бүрдүүлвэр 264 ширхэг, бүртгэлийн журнал 100 ширхэг жагсаалтаар хүлээн авч журмын дагуу архивт байрлуулсан болно.

Лавлагаа олгодог бүх албан хаагчдаас сар бүрийн 25-наар тасалбар болгож лавлагааны мэдээг авч нэгтгэж тасгийн даргад танилцуулж мэдээг үнэн зөвөөр гаргаж ахлах нятлан бодогч болон УБЕГ-т хүргүүлж ажиллаж байна.



#### **4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:**

2020 оны 6 сарын байдлаар нийт 1368 шинээр нээсэн хувийн хэргийг архивт хүлээж авсан бөгөөд үүний 342 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, 288 нь газар, 738 нь газар эзэмших, ашиглах эрхтэй холбогдолтой хувийн хэрэг байна. Архиваас улсын бүртгэгчдэд 3031 хувийн хэргийг түр олгосон байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт бүгд 28109 хувийн хэрэг зохих журмын дагуу эмх цэгцтэй хадгалагдаж байна. Үүний 12176 нь газартай холбогдолтой хувийн хэрэг,

13718 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдолтой хувийн хэрэг, 2215 нь газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой хувийн хэргүүд байна.

Хууль хяналтын байгууллагаас ирсэн албан тоотын хариуг 121 хувийн хэрэгт баяжилт хийж байршуулсан болно. Хяналтын улсын байцаагчид тайлант улирлын хугацаанд 19 хувийн хэргийг түр олгож архивт хүлээж авсан. Хууль хяналтын байгууллагын албан тоотыг үндэслэн 4 хувийн хэрэгт үзлэг хийлгэсэн болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар бүртгэл хүчингүй болж хувийн хэрэг хаасан 21 хувийн хэргийг сангаас хасаж хадгаламжийн нэгж үүсгэж үдсэн болно. Элэгдэж ашиглах боломжгүй болсон 1 улсын бүртгэгчийн тамга тэмдгийг хураан авч УБЕГ-т хүргүүлсэн. Шинээр улсын бүртгэгчээр томилогдсон 2 улсын бүртгэгчид тамга тэмдгүүдийг нь хууль журмын дагуу хүлээлгэж өгсөн.

#### **4.3. Хуулийн этгээдийн архивын чиглэлээр:**

Тайлант хугацаанд 78 анхны бүртгэлийн хувийн хэргийг архивт хүлээн авч улсын бүртгэлийн дугаарын дэс дарааллын дагуу байршуулсан болно. Үүнээс ХХК-53, хоршоо-3, ХЗХ-1, НҮТББ-19, ҮЭБ-2 хувийн хэрэг байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс 174 хувийн хэргийн баяжилтыг хүлээн авч, зохих журмын дагуу байрлуулсан болно. Өнөөдрийн байдлаар хуулийн этгээдийн архивт нийт 2052 хувийн хэрэг хадгалагдаж байна.

### **ТАВ. ХЭЛТСИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **5.1. Мэдээллийн технологи, програм хангамжийн ажлын хүрээнд:**

Хууль зүйн сайдын 2014 оны А/146 тоот тушаалаар баталсан “Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг мөрдлөг болгож, мэдээллийн технологийн төлөвлөгөө гаргаж, хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын нийт албан хаагчдын тоног, төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, сүлжээний доголдол, мэдээллийн аюулгүй байдал, Иргэний шинэчилсэн бүртгэлийн тоног төхөөрөмжинд шинэчлэл хийх, гарсан гэмтлийг яаралтай засах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Ажлын хэрэглээний компьютерүүдэд цаг тухайд нь үйлчилгээ хийж, техникийн засварын дэвтэр хөтлөн бүртгэж авдаг. Сумын газар нутгийн байршлаас хамааран

нэгжийн шинэчлэлт харилцан адилгүй хийгддэг. Програм болон техник хангамжийн суурилуулалт түүний шинэчлэл, тохиргоог тухай бүр хийж байгаа.

Тус хэлтэст нийт 34 компьютер, 32 хэвлэгч төхөөрөмжтэй. Үүнээс хэлтсийн доторх техник хэрэгслүүд хэвийн ажиллагаатай, анхан шатны улсын бүртгэгч нарын иргэний шинэчилсэн бүртгэлийн техник хэрэгслүүдийн ашиглалтын хугацаа дууссан эвдрэл их гарч байна.

Тайлант хугацаанд хэлтсийн албан хаагчдын компьютерт давхардсан тоогоор 29 удаа үйлчилгээ хийсэн бөгөөд 9 компьютерыг форматалж, бүртгэлийн болон хэрэглээний бүх програм хангамжийг суулгаж ажиллаж байна. Afis, дахин олголтын гэрчилгээний програм, ePRS1, ePRS2 систем, хуулийн этгээдийн архивын програм, цахим архив програм, иргэний улсын бүртгэлийн туршилтын шинэ систем болон офлайн программын шинэчлэлүүдийг холбогдох улсын бүртгэгч, архивч нарт цаг тухайд нь суулгаж өгсөн. Цахилгааны хэлбэлзлийн улмаас хэлтсийн төвийн эд хөрөнгийн эрхийн 1 улсын бүртгэгчийн болон мэдээллийн технологийн ажилтны DELL маркийн суурин компьютерийн video chip нь шатсан. Дэлүүн сумын Canon 1000D зургийн аппарат USB оролт нь эвдэрсэн ашиглалтын хугацаа нь дууссан, компьютерт орж ирэхгүй байсан тул дүгнэлтийн хамт МТГ-т хүргүүлэн шинээр солиулж авсан болно.

Сүлжээний тоног, төхөөрөмж болон бүртгэгчдийн тоног төхөөрөмжийн бүртгэл тогтмол хөтөлж байгаа ба эвдрэл, гэмтэл гарсан үед бүртгэж авч, завсар үйлчилгээ хийсэн талаар тэмдэглэл хөтөлдөг.

Сүлжээний төхөөрөмж болон хэрэглэгчийн сүлжээний кабелийн үзүүрт тэмдэглэгээ хийгдсэн. Дотоод, гадаад сүлжээний хэвийн ажиллагаатай. Серверийн өрөөнд хөргөлтийн системтэй шинэ Rack байршуулсан. 7 хоногт 1 удаа энгийн цэвэрлэгээ, 14 хоногт 1 удаа чийгтэй цэвэрлэгээ, улиралд 1 удаа их цэвэрлэгээ хийгддэг. Сүлжээний тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байна.

Аймгийн төвийн хэлтсийн сүлжээг MobiNet компаниас авдаг байсныг 2020 оны 01-р сарын 02-ны өдрөөс эхлэн “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн сүлжээнд шилжүүлсэн. Ингэснээр сүлжээний тасалдал багасч, хурд нь нэмэгдсэн.


2020 оны 2-р сарын 19-20-ны өдрүүдэд Булган сумын онлайн сүлжээ байнга тасалдаж муу ажиллагатай байсныг тогтоон, сүлжээний роутерийн портыг сольж хэвийн ажиллагааг хангасан.

Хэлтсийн төвийн иргэний бүртгэлийн сүлжээг дамжуулж буй FortiNet 80c роутерийн адаптер ажиллагаагүй болсныг шинээр сольсон.





**ӨЛГИЙ СУМЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН БҮРТГЭЛИЙН  
СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГ**



**5.2. Хүний нөөцийн ажлын хүрээнд:**

УБЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 тоот тушаалаар баталсан Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоогоор 36 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд: төрийн захиргааны албан хаагч 28, төрийн үйлчилгээний албан хаагч 5, гэрээт ажилтан 3 болно. Тус байгууллагад ажиллаж байгаа нийт албан хаагчдын 21 нь эмэгтэй буюу 58,3%, эрэгтэй 15 буюу 41,6%-ийг тус тус эзэлж байна.

Төрийн албаны зөвлөлөөс батлагдсан төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу албан хаагчдийн хувийн хэргийн баяжилт болон шинээр томилогдсон албан хаагчдын хувийн хэргийг бичиг хэргийн ажилтанд хариуцуулан хийлгэж ЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэн ажиллав.

Байгууллагын хүний нөөцийн бодлогын хүрээнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

–“Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд:

–Хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны судалгааг гаргаж, цалингийн шатлал ахиулах шаардлагатай 20 албан хаагчийн цалингийн шатлал ахиулсан. Мөн зэрэг дэв шинээр олгох, ахиулах,

албан хаагчдын судалгааг Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлд уламжлан шийдвэрлүүлсэн.

–Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд /hr.csc.gov.mn/ хэлтсийн албан хаагчдын үндсэн цалин болон сар бүр тогтмол авч буй нэмэгдлийг нягтлан бодогчоор хянуулан, мэдээллийг үнэн зөв оруулсан. Мөн хүний нөөцийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөлт, баяжуулалтыг тогтмол хийж байна.

–Ар гэрийн гачигдал, хүүхэд асрах болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас чөлөө авахыг хүссэн албан хаагчдад чөлөө олгох ажлыг тухай бүр зохион байгуулж ажилласан.

–Шинээр хүүхэдтэй болсон 2 албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журмаар 100,000 төгрөг олгож, урамшуулав.

–Жендерийн тэгш байдлыг хангах үүднээс ажлын сул орон тоо гарсан буюу жирэмсний болон амаржсаны чөлөөтэй хугацаанд албан үүргийг түр орлон гүйцэтгэх 2 эмэгтэй албан хаагчийг ажилуулсан болно.

–COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэлтсийн нийт албан хаагчдын халууныг тогтмол хэмжүүлэн ажиллаж байна.



### **5.3. Санхүү, аж ахуй, хангамж үйлчилгээний ажлын хүрээнд:**

Хэлтсийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлж байна. 2020 оны эхний 5 сарын байдлаар улсын төсвөөс 207.387.200 төгрөгийн санхүүжилт авснаас 197.013.239 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ба энэ нь нийт төсвийн 94.9% байна. Мөн тайлант хугацаанд 79.166.666 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байсан ба 83.956.496,92 төгрөгийн орлого оруулж 6%-иар давуулан биелүүлсэн. Сар бүрийн 2-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн тайлан ба өглөг авлага, нэр данс зөрүүгийн тайланг ЕГ-т хүргүүлж ажиллаж байна. Үнэт цаасны зарцуулалтын тайлан болон орлогын тайланг хугацаанд нь ЕГ-т хүргүүлж байна. Одоогийн


байдлаар тус хэлтэс нь өр авлагагүйгээр ажиллаж байгаа болно. Мөн түүнчилэн ХАОАТ болон НДШ-ийн тайлангуудыг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хэлтсийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгүүлж “Зөрчилгүй” дүгнэлт авсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүдийг хуулинд заасан хугацаанд нь оруулж ажиллаж байна. Үнэт цаасны тооцоог сар болгон албан хаагч бүртэй хийж ажилласан.

Хэлтсийн төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст 2020 оны төсөв болон орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтийн 1-5 дугаар сарын мэдээнүүдийг хуульд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан.

#### **5.4. Үйл ажиллагааг тайлагнах ажлын хүрээнд:**

Улсын бүртгэлийн үйл ажиллагааг тайлагнах ажлын хүрээнд дараах тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллав. Үүнд:

- Аймгийн Засаг дарга болон Засаг даргын зөвлөлд Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж, хэлтсийн даргын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлэв. Цаашид бүртгэлийн үйл ажиллагааг улам сайжруулахад хамтран ажиллах талаар санал бодол солилцов.



- Иргэний бүртгэлийн тасгийн дарга Д.Аманбек иргэний бүртгэлийн хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаар аймгийн орон нутгийн радиод ярилцлага өгөв.



- Хяналтын улсын байцаагч А.Еркегүл Сонгуулийн тухай хуулийн 25.1-д заасны дагуу Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн санал авах өдрийн дараах өдрийг хүртэл түр зогсоохтой холбоотой болон бүртгэлийг хянан шалгах явцад гарч буй зөрчлийн талаар орон нутгийн телевизээр мэдээлэл хийв.
- Төрийн захиргааны албан хаагчийн 2019 оны ХАСХОМ-ын нэгдсэн тайлан,
- Хууль зүй, дотоод хэргийн дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажлын хүрээнд УБЕГ-аас 2020 онд хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жил, бүтэн жилийн биелэлт,
- Аймгийн засаг даргатай 2019 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний биелэлт,
- Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх сар бүрийн тоон мэдээг УБЕГ-т хүргүүлж ба хэлтсийн цахим хуудасны тоон мэдээ цонхонд тогтмол байршуулан ажиллаж байна.

Статистик тоон мэдээ

Иргэний бүртгэл - 2020 он

2020 - 5-р сарын 29, Бавсан гариг, 00:00

| Үйлчилгээний төрөл                    |         | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | Өссөн дүнгээр |
|---------------------------------------|---------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|--------|--------|---------------|
| 1. Нийт төрсний бүртгэл               |         | 245   | 189   | 238   | 273   | 271   |       |       |       |       |        |        |        | 1216          |
| үүнээс:                               | эрэгтэй | 119   | 97    | 127   | 144   | 146   |       |       |       |       |        |        |        | 633           |
|                                       | эмэгтэй | 126   | 92    | 111   | 129   | 125   |       |       |       |       |        |        |        | 583           |
| 1.1 Нөхөн бүртгэлд бүртгүүлсэн төрөлт |         | 1     | 3     | 5     | 2     | 1     |       |       |       |       |        |        |        | 12            |
| үүнээс                                | эрэгтэй | 0     | 3     | 3     | 2     | 1     |       |       |       |       |        |        |        | 9             |
|                                       | эмэгтэй | 1     | 0     | 2     | 0     | 0     |       |       |       |       |        |        |        | 3             |



|                                        |                            |      |      |     |     |     |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |      |
|----------------------------------------|----------------------------|------|------|-----|-----|-----|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|------|
| 11. Аймаг хотоос бүрмөсөн шилжин ирсэн |                            | 29   | 52   | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 81   |
| үүнээс                                 | насанд хүрэгч              | 23   | 44   | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 67   |
|                                        | хүүхэд /16-аас доош насны/ | 6    | 8    | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 14   |
| 12. Хот доторх шилжилт хөдөлгөөн       |                            | 1378 | 699  | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 2077 |
| 12.1 Сум хооронд шилжин ирсэн          |                            | 204  | 178  | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 382  |
| үүнээс                                 | насанд хүрэгч              | 140  | 128  | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 268  |
|                                        | хүүхэд /16-аас доош насны/ | 64   | 50   | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 114  |
| 12.2 Баг хооронд шилжин ирсэн          |                            | 1174 | 521  | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1695 |
| үүнээс                                 | насанд хүрэгч              | 730  | 311  | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1041 |
|                                        | хүүхэд /16-аас доош насны/ | 444  | 210  | 0   | 0   | 0   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 654  |
| 13. Лавлагаа                           |                            | 1306 | 1279 | 953 | 817 | 872 |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 5227 |
| үүнээс                                 | Албан тоотоор              | 12   | 44   | 30  | 69  | 112 |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 267  |
|                                        | Албан хэрэгцээнд           | 118  | 96   | 56  | 73  | 65  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 408  |
|                                        | Иргэнд                     | 1176 | 1139 | 867 | 675 | 695 |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 4552 |

### Хуулийн этгээдийн бүртгэл-2020 он

2020 - 5-р сарын 27, Лхагва гариг, 08:50



| Үйлчилгээний төрөл                                             | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | Өссөн дүнгээр |
|----------------------------------------------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|--------|--------|---------------|
| Хязгаарладмал хариуцлагатай компани                            | 7     | 14    | 7     | 7     | 11    |       |       |       |       |        |        |        | 46            |
| Хоршоо                                                         | -     | -     | 1     | -     | 1     |       |       |       |       |        |        |        | 2             |
| Нөхөрлөл                                                       | -     | -     | 1     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 1             |
| Төрийн бус байгууллага                                         | 1     | 2     | 3     | 2     | 1     |       |       |       |       |        |        |        | 9             |
| Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар | -     | -     | 3     | 2     | -     |       |       |       |       |        |        |        | 5             |
| Шашны байгууллага                                              | -     | -     | -     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 0             |
| Үйлдвэрчний эвлэлийн байгууллага                               | -     | -     | 1     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 1             |
| Хадгаламж зээлийн хоршоо                                       | 1     | -     | -     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 1             |
| Дахин гэрчилгээ олгосон                                        | 1     | 2     | 3     | 4     | -     |       |       |       |       |        |        |        | 10            |
| Нэмэлт өөрчлөлт                                                | 8     | 14    | 15    | 5     | 15    |       |       |       |       |        |        |        | 57            |
| Нэр баталгаажуулсан                                            | 24    | 20    | 19    | 20    | 14    |       |       |       |       |        |        |        | 97            |
| Тамга, тэмдгийн хяналтын дугаар                                | 10    | 20    | 20    | 14    | 19    |       |       |       |       |        |        |        | 83            |
| Татан буудсан                                                  | -     | -     | -     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 0             |
| Салбар                                                         | 2     | 1     | 1     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 4             |
| Лавлагаа                                                       | 32    | 12    | 23    | 32    | 29    |       |       |       |       |        |        |        | 128           |

## Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-2020 он

2020 - 5-р сарын 28, Пүрэв гариг, 09:31



| Үйлчилгээний төрөл           |                                                                                                         | 1 сар                   | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | Өссөн дүнгээр |
|------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|--------|--------|---------------|
| Хүлээн авсан мэдүүлгийн тоо  | Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх                                                           | 390                     | 439   | 306   | 440   | 455   |       |       |       |       |        |        |        | 2030          |
|                              | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх                                                                      | 337                     | 361   | 252   | 325   | 350   |       |       |       |       |        |        |        | 1625          |
| 1. Анхны бүртгэл             | Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх                                                 | 61                      | 80    | 55    | 44    | 34    |       |       |       |       |        |        |        | 274           |
|                              | Төрөөс худалдаж авсан үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгэх                                | 1                       | -     | 2     | 3     | -     |       |       |       |       |        |        |        | 6             |
|                              | Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар                                            | 2                       | 7     | 3     | 2     | 3     |       |       |       |       |        |        |        | 17            |
|                              | Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх                                               | 11                      | 11    | 7     | 6     | 2     |       |       |       |       |        |        |        | 37            |
|                              | Газраас бусад ҮХЭХ өмчлөх эрхийг анх удаа бүртгэх                                                       | 58                      | 85    | 45    | 51    | 58    |       |       |       |       |        |        |        | 297           |
|                              | Төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийг баталгаажуулах                                                | 1                       | -     | -     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 1             |
|                              | Худалдах, худалдан авах гэрээ                                                                           | 43                      | 57    | 33    | 76    | 83    |       |       |       |       |        |        |        | 292           |
| 2. Өмчлөх эрх шилжих гэрээ   | Бэлэглэх гэрээ                                                                                          | 20                      | 28    | 15    | 17    | 20    |       |       |       |       |        |        |        | 100           |
|                              | Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх                                                                     | 10                      | 13    | 18    | 11    | 16    |       |       |       |       |        |        |        | 68            |
|                              | Албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх                                                        | 2                       | -     | -     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 2             |
|                              | Хамтран өмчлөгч өөрчлөгдөх                                                                              | 12                      | 11    | 2     | 8     | 6     |       |       |       |       |        |        |        | 39            |
|                              | Эд хөрөнгийн үнэ өмчлөгчийн овог нэр өөрчлөгдөх                                                         | -                       | -     | -     | 1     | -     |       |       |       |       |        |        |        | 1             |
|                              | Өмчлөгчийн үүсгэн байгуулсан ХЭ-ээс иргэнд, иргэнээс үүсгэн байгуулсан ХЭ-ийн өмчлөлд өмчлөх эрх шилжих | -                       | 3     | -     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 3             |
|                              | Барьцаалбартай барьцааны гэрээ                                                                          | 82                      | 70    | 73    | 108   | 103   |       |       |       |       |        |        |        | 436           |
| 3. Барьцааны гэрээ           | Барьцаалбаргүй барьцааны гэрээ                                                                          | 139                     | 125   | 104   | 114   | 105   |       |       |       |       |        |        |        | 587           |
|                              | Барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах                                                       | 8                       | 4     | 8     | 8     | 12    |       |       |       |       |        |        |        | 40            |
|                              | Барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах                                                       | 13                      | 24    | 15    | 73    | 100   |       |       |       |       |        |        |        | 225           |
|                              | Барьцааны гэрээ дуусгавар болгох                                                                        | 186                     | 191   | 134   | 177   | 200   |       |       |       |       |        |        |        | 888           |
|                              | 4. Бусад гэрээ                                                                                          | Түрээсийн гэрээ бүртгэх | 1     | -     | 1     | -     |       |       |       |       |        |        |        | 2             |
| 5. Бүртгэлд өөрчлөлт оруулах | Эд хөрөнгийн хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх                                                          | 45                      | 49    | 21    | 25    | 28    |       |       |       |       |        |        |        | 168           |
|                              | Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх                                                                            | 11                      | 18    | 9     | 13    | 15    |       |       |       |       |        |        |        | 66            |
|                              | Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх                                                                       | -                       | -     | 1     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 1             |
|                              | Газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх                                                                  | 4                       | 3     | 2     | 3     | 9     |       |       |       |       |        |        |        | 21            |
|                              | Үрэйдүүлсэн гэрчилгээ шинээр олгох                                                                      | 4                       | 3     | -     | 4     | -     |       |       |       |       |        |        |        | 11            |
|                              | Гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох                                                                        | -                       | 1     | -     | -     | -     |       |       |       |       |        |        |        | 1             |
|                              | Өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөгдөх                                                                | -                       | 1     | -     | 1     | -     |       |       |       |       |        |        |        | 2             |
| 6. Лавлагаа, хуулбар         |                                                                                                         | 11                      | 7     | 8     | 12    | 9     |       |       |       |       |        |        |        | 47            |
| 7. Хувийн хэрэг хаах         |                                                                                                         | 2                       | 9     | 2     | 8     | 2     |       |       |       |       |        |        |        | 23            |



## **5.5. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд:**

Хэлтсийн үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж ирсэн ба санал хүсэлт, мэдээллийг төрөлжүүлэн дүгнэж, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж байна. Өдөр тутмын үйл ажиллагаа болон улсын бүртгэлийн бүртгэгчдийн үйлчилгээ, зан харилцааны асуудлаарх иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийг тухай бүр хэлтсийн дарга биечлэн хүлээн авч шийдвэрлэн, иргэдэд ойлгомжгүй байгаа асуудлыг Тасгийн дарга нараар тайлбарлуулан иргэдэд үйлчилж байна.

Авлига, ашиг сонирхол зөрчлийн талаар мэдээлэл ирээгүй байна. Тайлангийн хугацаанд /2020.06.18-ны өдрийн байдлаар/ хууль хяналтын болон бусад байгууллагуудаас 777 албан бичиг хүлээн авсан байх ба нийтдээ 858 албан бичиг гадагш явуулсны 575 нь хууль, хяналтын байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичиг болно.

Мөн хэлтсийн даргын 15 тушаалыг гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Оны эхнээс /2020.06.15/ иргэдээс нийт 128 өргөдөл хүлээн авч, Хэлтсийн даргад танилцуулан холбогдох албан хаагчдад цохилт хийлгэж, хугацаанд нь шийдвэрлүүлсэн. Үүнээс: Захиргаа удирдлагад 3 өргөдөл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 6, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 9 өргөдөл ирсэн байх ба Иргэний бүртгэл болон Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргахтай холбоотой /үрчлэлт, төрөлт, нас баралт, гэрлэлт, гэрлэлт дуусгавар болсоныг бүртгүүлэх мөн регистрийн дугаар зөвөтгөх, гэрчилгээ дахин олгох, тодорхойлолт, лавлагаа олгохдоо холбоотой 110 байна.


2020 оны 06 сарын 15-ны байдлаар нийт 128 иргэний өргөдлөөс 120 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад шилжүүлсэн 1, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 0, хугацаа болоогүй 7 иргэний өргөдөл хяналтад байна. Мөн шийдвэрлэлтийн хувь 93.8%-тай байна.

Иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилвал иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний баримт бичгийн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байгаа ба иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байгаа болно. Мөн иргэдийн өргөдөл, гомдлыг Хэлтсийн 70427810, 70427766 дугаарын утсаар авч ажиллаж байна.

Өргөдөл гомдлын мэдээг загвар хүснэгт дагуу гаргаж, улирлын сүүлийн сарын 15-ны дотор УБЕГ-ын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнд баталгаажуулан хүргүүлж байна.

Мөн хэлтсийн цахим хуудасны өргөдөл, гомдлын цонхонд тогтмол байршуулж байгаа болно.

Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаарх албан даалгаврыг ажилтнууддаа танилцуулан, хэлтсийн ажилтнуудын цагийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулан, өглөө болгон цагийн бүртгэлтэй танилцаж, чиглэл өгч ажилласан. Сумдын анхан шатны бүртгэгчдийн цаг ашиглалтын байдалд сумын Засаг даргын тамгын газартай хамтран хяналт тавин ажиллаж байна.



### **5.6. Сургалт, сурталчилгаа, ил тод нээлттэй байдал**

2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27 удаагийн сургалт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 417 хүн хамрагдсан байна.

| Д/д | Он, сар, өдөр | Хаанаас зохион байгуулсан | Хэлбэр | Сургалтын агуулга                                    | Хамрагдсан тоо | Тайлбар                             |
|-----|---------------|---------------------------|--------|------------------------------------------------------|----------------|-------------------------------------|
| 1   | 2             | 3                         | 4      | 5                                                    | 6              | 7                                   |
| 1   | 2020.01.03    | УБХ, ИБТ                  | Онлайн | Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой                       | 15             | Сумдын улсын бүртгэгч нар хамрагдав |
| 2   | 2020.01.04    | УБЕГ, ХЭБГ                | Онлайн | Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн тухай | 1              | Улсын бүртгэгч Б.Сауле хамрагдав    |
| 3   | 2020.01.17    | УБЕГ,                     | Онлайн | 2020 оны гүйцэтгэлийн                                | 1              | Хэлтсийн дарга                      |

|    |                  |                                            |        |                                                                                                                                      |    |                                                                       |
|----|------------------|--------------------------------------------|--------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|-----------------------------------------------------------------------|
|    |                  | БТДШГ                                      |        | төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар мэдээлэл өгөх" сургалт                                                                  |    | С.Арман хамрагдав                                                     |
| 4  | 2020.02.07       | УБЕГ, БТДШГ                                | Онлайн | 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар мэдээлэл өгөх" сургалт                                            | 27 | Хэлтсийн төрийн захиргааны албан хаагчид хамрагдав.                   |
| 5  | 2020.02.11       | Нийгмийн даатгалын хэлтэс                  | Танхим | Нийгмийн даатгалын тухай хуулийн талаар ойлголт                                                                                      | 20 | Хэлтсийн төвийн албан хаагчид хамрагдав.                              |
| 6  | 2020.02.14       | УБХэлтсийн дарга С.Арман                   | Танхим | Байгууллагын уур амьсгал, харилцааны талаар хичээл оров                                                                              | 20 | Хэлтсийн төвийн албан хаагчид хамрагдав                               |
| 7  | 2020.03.06       | УБЕГ, ИУБГ                                 | Онлайн | Сонгогчийн нэрийн жагсаалт хэвлэх, хэсэг оноох                                                                                       | 6  | Хэлтсийн дарга, ХУБ, ИУБТасгийн (төвийн) албан хаагчид хамрагдав.     |
| 8  | 2020.03.09       | Хууль зүйн туслалцааны дарга Т.Костёр      | Танхим | Хамт олны уур, амьсгал, харилцааны соёл                                                                                              | 20 | Төвийн албан хаагчид                                                  |
| 9  | 2020.03.23       | УБХ, ЭХЭУБТ, К.Ерке                        | Танхим | Улсын бүртгэгчийн эрх үүрэг                                                                                                          | 16 | Төвийн улсын бүртгэгчид                                               |
| 10 | 2020.03.23       | УБХэлтсийн дарга С.Арман                   | Танхим | Улсын бүртгэлийн байгууллагын нууц хамгаалах журам, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт                                       | 21 | Хэлтсийн төвийн албан хаагчид хамрагдав                               |
| 11 | 2020.03.23       | УБЕГ, ЭХЭУБГ                               | Онлайн | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд гарч буй нийтлэг алдаа, цахим систем боловсруулахад анхаарах асуудал                      | 6  | Хэлтсийн дарга, ХУБ, ЭХЭУБ тасаг                                      |
| 12 | 2020.03.24       | УБХэлтсийн дарга С.Арман, УБүртгэгч К.Ерке | Онлайн | Улсын бүртгэлийн байгууллагын нууц хамгаалах журам, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, Улсын бүртгэгчийн эрх үүргийн талаар | 14 | Сумдын улсын бүртгэгч нар хамрагдав                                   |
| 13 | 2020.04.15-04.16 | УБЕГ                                       | Онлайн | Удирдах ажилтны сургалт                                                                                                              | 5  | Хэлтсийн дарга, ИУБ, ЭХЭУБ-ийн тасгийн дарга, ХЭБ, Нягтлан, МТАжилтан |
| 14 | 2020.04.17       | УБЕГ, ТГ                                   | Онлайн | Бичиг хэргийн ажилтны сургалт                                                                                                        | 1  | Бичиг хэргийн ажилтан Х.Агжайх                                        |


|    |            |            |        |                                                                                                                                             |     |                                                                              |
|----|------------|------------|--------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|------------------------------------------------------------------------------|
| 15 | 2020.04.17 | УБЕГ, ИУБГ | Онлайн | Иргэний улсын бүртгэлийн системийн сонгуулийн модулийн танилцуулга                                                                          | 5   | ИУБ тасаг                                                                    |
| 16 | 2020.04.23 | УБЕГ, ИУБГ | Онлайн | Иргэний улсын бүртгэлийн шинэ системийн туршилт                                                                                             | 5   | ИУБ тасаг                                                                    |
| 17 | 2020.04.30 | УБЕГ, ХЭБГ | Онлайн | Хуулийн этгээдтэй холбоотой хууль, журмын хэрэгжилт, анхаарах асуудал                                                                       | 1   | Улсын бүртгэгч Б.Сауле хамрагдав                                             |
| 18 | 2020.05.06 | УБЕГ, ХШГ  | Онлайн | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт                                                | 1   | ХУБ А.Еркегүл хамрагдав                                                      |
| 19 | 2020.05.07 | УБЕГ, ХШГ  | Онлайн | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт                                               | 1   | ХУБ А.Еркегүл хамрагдав                                                      |
| 20 | 2020.05.08 | УБЕГ, ХШГ  | Онлайн | Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт                                                         | 1   | ХУБ А.Еркегүл хамрагдав                                                      |
| 21 | 2020.05.13 | УБЕГ, ХШГ  | Онлайн | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт                                                | 1   | ХУБ А.Еркегүл хамрагдав                                                      |
| 22 | 2020.05.14 | УБЕГ, ХШГ  | Онлайн | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт                                               | 1   | ХУБ А.Еркегүл хамрагдав                                                      |
| 23 | 2020.05.15 | УБЕГ, ХШГ  | Онлайн | Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр боловсруулсан хяналтын улсын байцаагчийн дүгнэлт                                                         | 1   | ХУБ А.Еркегүл хамрагдав                                                      |
| 24 | 2020.05.21 | УБХ        | Онлайн | Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн сургалт | 108 | Итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдав                                            |
| 25 | 2020.05.26 | УБЕГ, ТГ   | Онлайн | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт                                                                                                    | 6   | Хэлтсийн дарга, ХУБ, ИУБ, ЭХЭУБ-ийн тасгийн нар, ХЭУБ Б.Сауле, УБ Ш.Еркинбек |

|                            |                  |          |        |                                                                                                                                                              |     |                                                                             |
|----------------------------|------------------|----------|--------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|-----------------------------------------------------------------------------|
|                            |                  |          |        |                                                                                                                                                              |     | нар хамрагдав                                                               |
| 26                         | 2020.05.27       | УБЕГ, ТГ | Онлайн | Хүүхдийн эрх, Аюулгүй байдлыг хангах тухай                                                                                                                   | 5   | Хэлтсийн дарга, ХУБ, ИУБ, ЭХЭУБ-ийн тасгийн дарга нар, МТАжилтан хамрагдав. |
| 27                         | 2020.06.12-06.13 | УБХ      | Танхим | Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан ирц бүртгэлийн программын сургалт | 108 | Итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдав                                           |
| Нийт хамрагдсан хүний тоо: |                  |          |        |                                                                                                                                                              | 417 |                                                                             |

2020 оны 2-р сарын 04-ны өдөр сумдын Засаг дара нарын сургалтанд оролцож, Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд сумдын удирдлагын оролцоо сэдэвт мэдээлэл хийж, санал солилцов.






2020 оны 2-р сарын 14-ны өдөр хэлтсийн дарга С.Арман хэлтсийн албан хаагчдад Байгууллагын уур амьсгал, харилцааны талаар хичээл орлоо.




2020 оны 3-р сарын 23-ны өдөр хэлтсийн дарга С.Арман Улсын бүртгэлийн байгууллагын нууц хамгаалах журам, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч К.Ерке

Улсын бүртгэгчийн эрх, үүргийн талаар хичээл орлоо. Сургалтад сумдын улсын бүртгэгч нарт онлайнаар холбогдов.



2020 оны 05-р сарын 21-ний өдөр Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад цахим сургалт хийлээ. Сургалтад тус аймгийн 96 хэсэгт ажиллах 108 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдав.



Сургалтын үеэр зохион байгуулагч болон Тагнуулын газраас итгэмжлэгдсэн ажилтны чиг үүрэг, гүйцэтгэх ажил, УИХ-ын сонгуулийн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, иргэний улсын бүртгэл ба сонгогчийн бүртгэл, нэрсийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам зэрэг сэдвээр мэдээлэл өглөө.



**БАТЛАВ:УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ**  
С.АРМАН

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТАНД ЗОРИУЛСАН ЦАХИМ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**НЭГ. СУРГАЛТЫН ЗОРИЛГО**

1.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахад оршино.

**ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА**

2.1 Сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 10 цагт цахимаар зохион байгуулна. Сургалтанд Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид, санал авах байрны дэргэд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдана.

**ГУРАВ.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

| Хугацаа     | Сэдэв                                                                                                                                                                       | Хариуцах ажилтан                          |
|-------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|
| 08.30-09.00 | Онлайн холболт, бүртгэл                                                                                                                                                     | Бичиг хэрэг, МТА                          |
| 09.00-09.10 | Сургалтын нээлтийн ажиллагаа                                                                                                                                                | Хэлтсийн дарга С.Арман                    |
| 09.10-10.00 | -Монгол улсын Сонгуулийн тухай хууль,<br>-Итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулах,<br>нууцын баталгааны талаар анхаарах асуудал<br>-Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал. | Хэлтсийн дарга С.Арман                    |
| 10.00-10.30 | -Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт,<br>мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах талаар                                                                                   | Таннуулын газрын ажилтан<br>Б.Отгонбаатар |
| 10.30-12.00 | -Иргэний улсын бүртгэл ба сонгогчийн бүртгэл<br>-Сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам,<br>-Итгэмжлэгдсэн ажилтны чиг үүрэг, гүйцэтгэх ажил               | ИУБГ-ийн дарга Д.Аманбек                  |

**ДӨРӨВ.БУСАД**

4.1 Сургалтыг Улсын бүртгэлийн хэлтэс зохион байгуулж, бэлтгэл ажлыг сумын улсын бүртгэгч нар бие даан хариуцна.

4.2 Сургалтаар итгэмжлэгдсэн ажилтныг байгуулсан гэрээ, нууцын баталгааг сумдын улсын бүртгэгч нар хариуцан бичүүжлэн, 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөрт багтаан УБХ-т ирүүлнэ.


4.3 Сургалт зохион байгуулагдах өдөр Баян-Өлгий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийг хариуцаж УБЕГ-ын Хяналт, шалгалтын газрын дарга Б.Ганзориг хяналт тавьж ажиллана.

4.4 УБХ-ийн Мэдээллийн технологийн ажилтан Т.Батырхан онлайн холболтын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.

4.5 Сумдын улсын бүртгэгч нар сургалтын явцад итгэмжлэгдсэн ажилтнуудыг бүрэн ханруулж, хариуцлагатай ажиллана.

4.6 Сургалтанд хамрагдаж байгаа итгэмжлэгдсэн ажилтнууд онцгой байдлын үед мөрдөж ажиллах дэглэм /амны хаалт, бээлий, хувийн ариун цэвэр, хосрондын зай-ийг сахиж ажиллана.

-----oO-----



2020 оны 06-р сарын 12-13-ны өдрүүдэд Монгол Улсын Их Хурлын сонгуулиар ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын ирц бүртгэлийн программын сургалтыг зохион байгуулав. Сургалтын багийн ахлагчаар УБЕГ-ын ХШГ-ын дарга Б.Ганзориг, гишүүнээр ИУБГ-ын улсын бүртгэгч Ч.Батцэцэг, МТГ-ын инженер Э.Төртогтох нар оролцов.

**БАТЛАВ-УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛВАНҮҮДГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ С.АРМАН**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТНУУДЫН  
ИРЦ БҮРТГЭЛИЙН ПРОГРАММЫН НЭГДСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**НЭГ. СУРГАЛТЫН ЗОРИЛГО**

1.1 Мөнгөл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгах, ирц бүртгэлийн программд хэрхэн ажиллах талаар улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахад оршино.

**ХӨӨР, ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА**

2.1 Сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд танхимаар зохион байгуулна. Сургалтад санал авах байрны дэргэд ажиллах нийт 108 итгэмжлэгдсэн ажилтан оролцоно.  
2.2 Сургалтыг Өлгий сумын 1 дүгээр бүрэн дунд сургуулийн Хурлын зааланд зохион байгуулна.

**ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**2020 оны 6 дугаар сар 12-ны өдрийн сургалт**

| Хугацаа     | Сэдэв                                                                                                                                                                                                                                                                            | Хариуцах ажилтан                                                                              |
|-------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|
| 08.30-09.00 | Бүртгэл, биеийн халуун хэмжих                                                                                                                                                                                                                                                    | Бичиг хэрэг, Улсын бүртгэгч нар<br>Хэлтсийн дарга С.Арман                                     |
| 09.00-09.10 | Сургалтын нээлт, МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаарх товч илтгэл                                                                                                                                                                                        | Сургалтын багийн ахлагч Б.Ганзориг /УБЕГ-ын ХШГ-ын дарга/                                     |
| 09.10-09.25 | Мөнгөл улсын Сонгуулийн тухай хууль, тогтоомжийн талаарх илтгэл                                                                                                                                                                                                                  | Сургалтын багийн гишүүн Ч.Батцэцэг /ИУБГ-ын улсын бүртгэгч/<br>Улсын ахлах бүртгэгч Д.Аманбек |
| 09.25-09.40 | Завсарлага /Танхимд агааржуулалт хийх/                                                                                                                                                                                                                                           |                                                                                               |
| 09.40-10.00 | Санал авах өдөр итгэмжлэгдсэн ажилтны гүйцэтгэх үйл ажиллагаа, анхаарах асуудал                                                                                                                                                                                                  | Сургалтын багийн гишүүн Э.Төртөгтох инженер/ Т.Батырхан /МТА/                                 |
| 10.00-10.20 | Сонгогчдын ирц бүртгэлийн программ дээр хэрхэн ажиллах, сонгогчдын нэрийн жагсаалтад хэрхэн лавлагаагаар өөрчлөлт оруулах үйл ажиллагааны дэргэд ажиллах тухай                                                                                                                   | Сургалтын багийн гишүүн Э.Төртөгтох инженер/ Т.Батырхан /МТА/                                 |
| 10.20-10.30 | Завсарлага /Танхимд агааржуулалт хийх/                                                                                                                                                                                                                                           |                                                                                               |
| 10.30-11.30 | Дадлага ажил /Ирц бүртгэлийн программыг асаах, сонгогчийн ирц бүртгэлийг нээж нягтлан шалгах, сонгогчийн хувийн мэдээллийг ажиллуулах, сонгогчийн ирцийн мэдээ хэвлэх, бүртгэлийн хуудас хэвлэх, сонгогчдын нэрийн жагсаалтад тусгах лавлагааг ирц бүртгэлийн программд оруулах/ | Сургалтын багийн гишүүн Э.Төртөгтох инженер/ Т.Батырхан /МТА/                                 |

|             |                                                                                                                                                                                                   |                                                                                       |
|-------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|
| 11.30-12.30 | Үдийн завсарлага /Танхимд агааржуулалт хийх/                                                                                                                                                      |                                                                                       |
| 12.30-13.30 | Сонгогчийн ирц бүртгэлийн программ дээр ажиллах үйл ажиллагаа                                                                                                                                     | Сургалтын багийн гишүүн Э.Төртөгтох инженер/ Т.Батырхан /МТА/ Итгэмжлэгдсэн ажилтнууд |
| 13.30-13.40 | Танхимд агааржуулалт хийх                                                                                                                                                                         |                                                                                       |
| 13.40-16.40 | Сонгогчийн ирц бүртгэлийн программд итгэмжлэгдсэн ажилтнууд өөрийн ирц коддоор нэвтэрч СНЖ-д өөрчлөлт оруулах лавлагаа ирц бүртгэлийн программд оруулах. /1 цаг тутамд танхимд агааржуулалт хийх/ | Сургалтын баг, Итгэмжлэгдсэн ажилтнууд                                                |
| 16.40       | Их завсарлага                                                                                                                                                                                     |                                                                                       |

**2020 оны 6 дугаар сар 12-ны өдрийн сургалт**

| Хугацаа     | Сэдэв                                                                                                                                   | Хариуцах ажилтан                       |
|-------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|
| 08.30-09.00 | Бүртгэл, биеийн халуун хэмжих                                                                                                           | Бичиг хэрэг, МТА                       |
| 09.00-09.10 | Өдрийн сургалтын талаарх мэдээлэл                                                                                                       | Хэлтсийн дарга С.Арман                 |
| 09.10-09.20 | СНЖ хэвлэх үйл ажиллагаа ямар зохион байгуулалттай явагдахыг мэдээлэх                                                                   | Улсын ахлах бүртгэгч Д.Аманбек         |
| 09.20-12.00 | СНЖ хэвлэх, гарын үсэг зургах, баталгаажуулах, программыг түржх, битүмжлэх, лацдах үйл ажиллагааг хяналтан дор зохион байгуулж ажиллах. | Сургалтын баг, Итгэмжлэгдсэн ажилтнууд |
| 12.00-13.00 | Үдийн завсарлага                                                                                                                        |                                        |
| 13.00-17.00 | Үргэлжлэл                                                                                                                               | Сургалтын баг, Итгэмжлэгдсэн ажилтнууд |

**ДӨРӨВ. БУСАД**

- 4.1 Сургалтын бэлтгэл ажлыг Улсын бүртгэлийн хэлтэс хангаж ажиллана.
- 4.2 Сургалтын өдрүүдэд коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлж, хяналт тавьж ажиллана. Үүнд, танхимыг урьдчилан цэвэрлэж, ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн байна. Сургалтад оролцогчдын биеийн халууныг хэмжиж, гар халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж, амны хаалтаар хангана.
- 4.3 Цахилгааны хэлбэлзэл, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх асуудлыг Ахлах ня-бо А.Ертауке, Мэдээллийн технологийн ажилтан Т.Батырхан, жолооч А.Озбек нар хариуцаж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.
- 4.5 Сургалтын улсын бүртгэгч нар сургалтын явцад итгэмжлэгдсэн ажилтнуудыг бүрэн хариуцаж, хариуцлагатай ажиллана.
- 4.6 Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, принтер, бичгийн цаас, үдэж хавтаслах хэрэгсэл, дугуй, уртсагач залуур, бусад дагалдах техник тоног төхөөрөмжийг сургалтын 2 дахь өдөр бэлэн болгох асуудлыг Ахлах ня-бо А.Ертауке, нярав, бичиг хэргийн эрхлэгч Х.Алхайр, МТА Т.Батырхан нар хариуцаж ажиллана.


-----oO-----

**Сургалтын үеэр итгэмжлэгдсэн ажилтнуудын халууныг хэмжиж, амны хаалт, гар ариутгагч тараан онцгой байдлын дэг журмыг чанд сахин ажилласан болно.**



**2020 онд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр хамрагдах иргэдэд анхааруулах зорилгоор анонс хийж байгууллагын социал хуудсаар болон цахим хуудсаар түгээж ажиллав.**





Сонгуулийн тухай хуулийн 25.1-д заасны дагуу Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн санал авах өдрийн дараах өдрийг хүртэл түр зогсоохтой холбоотой мэдээллийг цахим хуудсаар дамжуулан сурталчилан ажиллав.

Монгол Улсад коронавируст халдвар /COVID-19/ бүртгэгдэж, улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.03.13-ны өдрийн А/259, А/554 дүгээр тушаалаар ажлын тусгай горимд шилжиж тушаалын хэрэгжилтийг ханган ажиллав. Иргэдэд үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарийн талаар цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллав.

COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ИРГЭН ТА бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг заавал өөрийн биеэр ирэхгүйгээр доорх НЭЭЛТТЭЙ УТАС болон ЦАХИМ хуудсаар дамжуулан авах боломжтой анонс хийж байгууллагын сошиал хуудсаар болон цахим хуудсаар түгээж ажиллав.

<https://burtgel.mn/> <http://ubh.bo.gov.mn> <http://www.facebook.com/ubh.bo.gov.mn>



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Дэлхийн олон улсад хурдацтай тархаж буй шинэ төрлийн **Коронавирусийн /COVID-19/** халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор **ИРГЭН ТА** олон нийтийн газраар шаардлагагүй тохиолдолд явахгүй байхыг анхааруулж байна.



**ТА** бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг заавал өөрийн биеэр ирэхгүйгээр доорх **НЭЭЛТТЭЙ УТАС** болон **ЦАХИМ** хуудсаар дамжуулан авах боломжтой.




**BURTGEL**.mn

 **7042 7810**  
3745

 **WWW**.ubh.bo.gov.mn  
.burtgel.mn

 <http://facebook.com/ubh.bo.gov.mn>  
Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтэс

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг <http://election.burtgel.gov.mn/> цахим хуудсанд байршуулсан. Үүнтэй холбогдуулан Сонгогч та <http://election.burtgel.gov.mn/> холбоосоор орж өөрийн бүртгэлийг баталгаажуулна уу баннерийг хэлтсийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж ажилласан ба үйлчилгээний зааланд компьютер байршуулан угтах үйлчилгээний ажилтнаар үйлчлэгчдийн мэдээллийг шалгуулан баталгаажуулалт хийлгэн ажиллаж байна.



Монгол Улсын иргэний үнэмлэхийн бүртгэлтэй холбоотой түгээмэл асуулт, хариулт нийтлэлийг хэлтсийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж ажилласан. [http://ubh.bo.gov.mn/index.php?option=com\\_content&view=article&id=1644:irgeni-unemleh](http://ubh.bo.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=1644:irgeni-unemleh)



[www.burtgel.mn](http://www.burtgel.mn) цахим хуудас болон иргэд цахим үнэмлэхээ онлайнаар захиалах боломжтой болсон талаар мөн шинэ хуулийн брошур, гарын авлагыг хэлтсийн цахим хуудас болон фэйсбук фэйжээр олон нийтэд сурталчилан ажиллав.



Бүртгэлийн нэгжийн статистик тоон мэдээгээр брошур хэвлэж аймгийн холбогдох төрийн байгууллагуудад, нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдэд тарааж, цахим хуудаст байршуулан харилцан мэдээлэл солилцож ажиллаж байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ



**Хуулийн этгээдийн тоо** 126

Тайлант хууцаанд шинээр байгуулагдсан:

|                                                                |    |
|----------------------------------------------------------------|----|
| Хягаарлагдмал харуулагатай компани                             | 85 |
| Төрийн бус байгууллага                                         | 15 |
| Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар | 8  |
| Нөхөрлөл                                                       | 0  |
| Хоршоо                                                         | 4  |
| Хадгаламж зээлийн хоршоо                                       | 1  |
| Сан                                                            | 0  |
| Үйлдвэрчний зөвлөлийн байгууллага                              | 8  |
| Шашны байгууллага                                              | 5  |
| Хөвөлн мэдээллийн байгууллага                                  | 0  |
| Боловсрол, сургалтын байгууллага                               | 0  |
| Татан буудсан                                                  | 0  |



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

/2019 оны статистик  
тоон мэдээ/



## ИРГЭНИЙ БҮРТГЭЛ



**Суурин хүн амын тоо** 103 870

|                                                                   |      |
|-------------------------------------------------------------------|------|
| Шинээр төрсөн                                                     | 3017 |
| МУ-ын харьяат болсон, саргэсэн, мэдээллийн санд нөхөн бүртгүүлсэн | 129  |
| Нас барсны бүртгэлд бүртгүүлсэн                                   | 500  |
| МУ-ын харьяатавс гарсан                                           | 92   |



**Хүйсийн ангиллаар**

|         |        |
|---------|--------|
| Эрэгтэй | 51 854 |
| Эмэгтэй | 52 016 |



**Архивын баримтын тоо** 250 873

|                                     |         |
|-------------------------------------|---------|
| Иргэний баримтын хувийн хэрг        | 222 268 |
| Хуулийн этгээдийн хувийн хэрг       | 1 955   |
| Эд хөрөнгийн бүртгэлийн хувийн хэрг | 26 650  |

## ИРГЭНИЙ БҮРТГЭЛ



**Иргэний үнэмлэх олголт** 5 393

|                     |      |
|---------------------|------|
| Шинээр олгосон      | 2076 |
| Дахин олгосон       | 492  |
| Хуваагдаж солигдсон | 2826 |



**Гадаад паспорт олголт** 5 627

|                 |       |
|-----------------|-------|
| Шинээр олгосон  | 5 617 |
| ОХУ-ын хавсралт | 10    |



**Гэрлэсний, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл** 861

|                                                                    |     |
|--------------------------------------------------------------------|-----|
| Гэрлэсний бүртгэл анхны нөхөн                                      | 816 |
| 804                                                                |     |
| 12                                                                 |     |
| Гэрлэлт дуусгавар болсон бүртгэл зааривчны журмаар шүүхийн журмаар | 45  |
| 12                                                                 |     |
| 33                                                                 |     |



**Хүүхэд үрчлэлтийн бүртгэл** 137

|                       |     |
|-----------------------|-----|
| Многол улсын иргэнд   | 137 |
| Гадаадын улсын иргэнд | 0   |



**Өвөг, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл** 52



**Шилжилт хөдөлгөөний бүртгэл** 3 165

|                              |      |
|------------------------------|------|
| Аймаг, хотосгоо шилжин ирсэн | 122  |
| Хот доторх шилжилт хөдөлгөөн | 1521 |
| Сум хооронд шилжсэн          | 799  |
| Баг хооронд шилжсэн          | 723  |

## ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛ



**Нийт хүлээн авсан мэдүүлгийн тоо** 8 796

|                                                 |      |
|-------------------------------------------------|------|
| Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх | 5195 |
| Газар өмчлөх, зээмшиг, ашиглах эрх              | 3601 |



**Анхны бүртгэл** 1 288

|                                                           |     |
|-----------------------------------------------------------|-----|
| Тарваас хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх  | 518 |
| Газраас бусад ҮХЗХ өмчлөх эрхийг анх удаа бүртгэх         | 608 |
| Тарваас хувьчилсан орон сууц өмчлөх эрхийг баталгаажуулах | 2   |
| Өмчлөгчийн хувиалээр бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах    | 31  |
| Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх | 129 |



**Өмчлөх эрх шилжих гэрээ** 1 045

|                                                |     |
|------------------------------------------------|-----|
| Худалдах, худалдан авах гэрээ                  | 592 |
| Балзлах гэрээ                                  | 198 |
| Өгч залгамжлалаар өмчлөх өөрчлөхөд             | 121 |
| Хамтран өмчлөх өөрчлөхөд                       | 120 |
| Эд хөрөнгийн үнэ өмчлөгчийн овог нэр өөрчлөхөд | 9   |
| Шүүхийн шийдвэрээр өмчлөх өөрчлөхөд            | 2   |
| Албадан буудагаа худалдаагаар өмчлөх өөрчлөхөд | 3   |



**Барьцааны гэрээ** 5 636

|                                                   |       |
|---------------------------------------------------|-------|
| Барьцаалбартай барьцааны гэрээ                    | 1 085 |
| Барьцаалбаргүй барьцааны гэрээ                    | 1 738 |
| Барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах | 136   |
| Барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах | 296   |
| Барьцааны гэрээ дуусгаар болох                    | 2 381 |




**Бүртгэлд өөрчлөлт оруулах** 796

|                                                      |     |
|------------------------------------------------------|-----|
| Газрын нэгж тайлбарын дугаар өөрчлөхөд               | 63  |
| Эд хөрөнгийн хагас, хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөхөд | 492 |
| Эд хөрөнгийн зориулалт өөрчлөхөд                     | 9   |
| Өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөхөд              | 8   |
| Үүсгүүлсэн эзэрчлэлээ, лавлагаа, хуульчлолт          | 191 |
| Хувийн хэргэ хах                                     | 33  |



"Амны хаалтаа зүүцгээе" аянд нэгдэж видео шторк хийж хэлтсийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж ажилласан. <https://youtu.be/VvE8I7Nvgno>  
<https://www.facebook.com/ubh.bo.gov.mn/videos/238727433879473/>



Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлогын баримт бичиг”, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

УБЕГ-ын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2020 оны 01-р сарын 23-ны өдрийн 9/658 дугаар зөвлөмжийн мөрөөр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Хэлтсийн цахим хуудасны мэдээллийг шинэчлэв. Тухайлбал:

- a. Иргэний бүртгэл цонхонд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалт, гэрчилгээний үнэ, үйлчилгээний хөлс, төлбөр тушаах дансны дугаар, бүртгэлд хамрагдах хуулийн хугацаа хэтэрсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар оногдох торгуулийн хэмжээ зэргийг бүрэн оруулсан. Мөн бүх төрлийн лавлагаа болон иргэний цахим үнэмлэхээ үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд УБЕГ-ын [www.burtgel.mn](http://www.burtgel.mn) цахим хуудсаар захиалах талаарх мэдээлэл байршуулсан.
- b. Эд хөрөнгийн эрхийн бүртгэл цонхонд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, улсын тэмдэгтийн хураамжийн үнэ, төлбөр тушаах дансны дугаар, үйлчилгээний хөлс, энгийн болон яаралтай үйлчилгээний хугацаа, мэдүүлгийн загвар зэргийг бүрэн оруулсан.

с. Хуулийн этгээдийн бүртгэл цонхонд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, нэрийн баталгаажуулалт, улсын тэмдэгтийн хураамжийн үнийн төлбөр тушаах дансны дугаар, УБ маягтуудыг татаж авахаар байршуулсан.

2. Байгууллагын үйлчилгээний стандартыг цахим хуудасны мэдээллийн ил тод байдал цонхонд шинэчлэн байршуулсан.
3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам хугацаанд байршуулж байна.

УБЕГ-ын Тамгын газраас ирүүлсэн Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн эх сурвалжийг нэг сувгаар түгээх асуумжинд дараах хариулт хүргүүлэв.

1. Танай газар /хэлтсийн/ цахим хуудсанд байршуулагдаж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл ямар хугацаанд шинэчлэгдэж байна вэ? 7 хоногт 2-оос 3 удаа

2. Бие даасан цахим хуудас байх шаардлагатай эсэх?

Хэлтсийн үйл ажиллагатай холбоотой мэдээ, мэдээлэл болон бүртгэлийн хууль тогтоомжийг олон нийтэд хүргэх, сурталчлахад бие даасан цахим хуудас байх шаардлагатай.

3. Цахим хуудас хөтлөхөд тулгарч буй бэрхшээл?

Тус хэлтсийн цахим хуудсын Мэдээллийн технологийн ажилтан хөтлөн ажилладаг тул ямар нэгэн тулгарч буй бэрхшээл байхгүй

4. Цахим хуудас хөтлөхөд нэг жилд зарцуулагдаж буй төсөв?


Төрийн байгууллагын цахим хуудсыг “Үндэсний дата төв” УТҮГ өөрийн сервер дээр байршуулан, "GOV.MN" домэйн нэр олгох үйлчилгээг хариуцан үнэгүй байршуулдаг тул ямар нэгэн төсөв зарцуулахгүй байгаа.

5. Бусад /санал /

Тус хэлтсийн цахим хуудас нь Joomla CMS /Агуулгын Удирдлагын Систем/-д хийгдсэн. Joomla CMS нь бэлэн загвар дээр хийгддэг учир хамгаалт муутай, халдлагад өртөх эрсдэл өндөр байдаг. Цахим хуудасны аюулгүй байдлыг хангаж, тогтвортой ажиллуулахын тулд орчин үеийн дэвшилтэт шинэ технологиор цахим хуудсаа шинэчлэх шаардлагатай байна.

## 5.7. Олон нийтийн ажлын хүрээнд

Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчид ашиглаж буй техник хэрэгсэл болон албаны өрөөнд ариутгалын бодисоор цэвэрлэгээ хийв. Мөн өрхийн эмнэлгийн эрүүл мэндийн ажилтнаар албан хаагчдын халууныг үзүүлэн ажиллаж байна.



Ковид-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх онцгой нөхцөл байдал үүсч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаагаар хойшлуулах шийдвэр гарсантай холбогдуулан гэртээ байгаа хүүхэд багачуудын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авьяас чадвараа хөгжүүлэх, нийгэмд оролцох эрхийг хангахад зорилгоор 2020 оны 4-р сарын 20-ноос 05-р сарын 20-ны өдрийн хооронд тус хэлтсийн эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын 12 хүртэлх насны хүүхдүүдийн дунд “Миний мөрөөдөл” сэдэвт гар зургийн цахим уралдаан зохион байгуулав.



**ГАР ЗУРГИЙН ЦАХИМ УРАЛДААНЫ  
УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

Ковид-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх онцгой нөхцөл байдал үүсч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаагаар хойшлуулах шийдвэр гарсантай холбогдуулан гэртээ байгаа хүүхэд багачуудын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авьяас чадвараа хөгжүүлэх, нийгэмд оролцох эрхийг хангахад оршино.

**Хоёр. Зохион байгуулагч**

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дэргэдэх Эцэг эхийн зөвлөл

**Гурав. Хамрах хүрээ**

Тус хэлтсийн албан хаагчдын 12 хүртэлх насны хүүхдүүдийн дунд.

**Дөрөв. Зохион байгуулах хугацаа**

2020.04.20-2020.05.20-ны өдрийн 17 цаг хүртэл

**Тав. Цахим уралдааны сэдэв**

"Миний мөрөөдөл"

**Зургаа. Шалгуур**

Уралдаанд оролцоходоо оролцогч өөрийн гараар зурсан байх, бүтээлч сэтгэл, шинэлэг санаа агуулсан байх.

Бүтээлийн зургийг нь энэхүү удирдамжийн сэтгэгдэл /comment/ хэсэгт нийтлэнэ. Нийтлэхдээ дараах зүйлийг анхаарна уу.

- "Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс"-ийн пэйж хуудсанд эцэг /эх/, асран хамгаалагч нь Like дарсан байх ба 20-оос доошгүй хүнийг Invite хийж, пэйж хуудсанд Like даруулсан байх
- Оролцогчийн овог, нэр, төрсөн огноог бичнэ.

**Долоо. Шагнал, урамшуулал**

Цахим уралдаанд оролцогчдын дундаас шинэлэг санааг гаргаж зурсан эхний 3 байр шалгаруулж, шагнаж урамшуулна. Шалгаруулахдаа пэйж хуудсанд даруулсан Like-ийн тоог харгалзан үзэх болно.

-oOo-

Үйлчилгээний зааланд бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд хүүхдээ саатуулах, хооллох, хуурайлах зориулалттай булан, ширээ, хүүхдийн сандал байршуулан иргэдийн тав тухыг ханган үйлчилгээ үзүүлж байна.





2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр Өлгий хотоос гарах чиглэлийн хуваарьт газарт их цэвэрлэгээ хийв.



### **5.8. Аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа, үүлзалтын талаар**

Аймгийн ЗДТГ, болон бусад төрийн байгууллагатай хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажилласан ба төрийн болон хууль хяналтын байгууллагад лавлагаа мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.


Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газраас залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулж байгаа "ЯТГАХ ТУСАМ НЯГТАЛ" аянд тус хэлтсийн албан хаагчид нэгдлээ.



Аймгийн Хууль зүйн туслалцааны төвийн дарга, ахмад хуульч Т.Костёрийг хэлтэс дээр урьж, “Хамт олны уур, амьсгал, харилцааны соёл” сэдэвт хичээл заалгав.



Шинэ төрлийн Корона вирус буюу /COVID-19/-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд тус хэлтсийн хамтран ажилладаг Баян-Өлгий аймаг дахь Улаан загалмайн хорооноос албан хаагчдад гар ариутгагчийн бодис Санитол, маск тарааж өгөв.




Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс тус хэлтсийн албан хаагчдад Нийгмийн даатгалын тухай хуулийн талаар мэдээлэл өгч, Улсын бүртгэл дэх үрчлэлтийн болон овог нэр, өөрийн нэр өөрчлөлтийн бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлын талаар хамтран ажиллах санал солилцов.



2020 оны 2-р сарын 28-ны өдөр Газрын харилцаа, хот байгуулалтын газрын удирдлагууд болон газрын даамалуудыг хэлтэс дээр урьж хамтарсан уулзалт зохион байгууллаа. Уулзалтанд дундын мэдээллийн сангаас дугаар олголт, газар эзэмших эрхийн бүртгэлтэй холбоотой санал солилцож, хамтран ажиллахаар тохиролцов.



Төрийн аудитын байгууллагаар тус хэлтсийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдэж "ЗӨРЧИЛГҮЙ" дүгнэлт авав.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА С.АРМАН ТАНАА

2020.02.13 № 81

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас Санхүүгийн тайланд аудит хийх журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Дэлхийн олон улс, оронд хурдацтай тархаж буй Коронавирусийн /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмжиж Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид нийгмийн хариуцлагаа ухамсарлан Аймгийн онцгой комисст 700,000 төгрөгийн сэтгэлийн хандив өргөлөө.



2020 оны 04-р сарын 03-ны өдөр Аймгийн Засаг дарга А.Гылымхан, ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга Ө.Хуралай нар Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж, төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх талаар санал солилцож, архивын өрөө нь цаашид багтаамжгүй болсныг онцлон тус хэлтсийг шинээр баригдаж буй Төрийн үйлчилгээний цогцолборт оруулан байраар хангахаа мэдэгдлээ.



2020 оны 05-р сарын 28-ны өдөр Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 20.9-т "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ" гэж заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалыг хэвлэж хэсгийн хороонд хүргүүлэн ажиллав.



## ЗУРГАА. САНАЛ

1.Тус аймгийн бүх сумд иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдож улсын бүртгэлийг программд шууд бүртгэж, лавлагаа олгож байна. Сүлжээний хурд удаан байгаа тул нэмэгдүүлэх шаардлагатай болно. Мөн сумдын улсын бүртгэгч нарын компьютер, тоног төхөөрөмж хуучирч ашиглалтын элэгдэлд орсон тул тоног төхөөрөмжийг нэн даруй шинэчлэх шаардлагатай байна.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сангийн чанар, хурдыг сайжруулах.

ТАНИЛЦСАН:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Б.БААСАНДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:

АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.АРМАН

